



ГАРЧИГ

- 2–3 Бодлогын нийтлэл
- 4–6 Зохицуулалтын мэдээ
- 7–8 Ярилцлага
- 9–10 Тогтвортой санхүүжилт
- 11 Компанийн засаглал, комплайнс
- 12–14 Финтек ба регтек
- 15–23 Судлаачийн индэр
- 24–25 Цахимаар үнэт эдлэл худалдан авах ямар эрсдэлтэй вэ?
- 26–27 Олон улсын зах зээлийн мэдээ
- 28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС” – ИЙН ХЭРЭГЖИЛТ: НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН 2025 ОНЫ ТӨЛӨВ

Монголын хөрөнгийн зах зээлд компанийн засаглал нь зөвхөн хууль, журмын хэрэгжилтийг хэмжих үзүүлэлт бус, хөрөнгө оруулагчдын итгэл, компанийн зах зээлийн үнэлгээ, урт хугацааны тогтвортой өсөлтийг тодорхойлох чухал хүчин зүйл болж байна. Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)–ноос боловсруулсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт – 2025 он” нэгдсэн судалгааны тайлан нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудын засаглалын өнөөгийн түвшин, ахиц дэвшил болон цаашид анхаарах асуудлыг нэгтгэн харуулжээ.

Тайланд 2025 оны жилийн эцсийн байдлаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 112 хувьцаат компанийн “Компанийн засаглалын кодекс” (цаашид “Кодекс” гэх)–ийн хэрэгжилтийг үнэлсэн байна.

Үнэлгээг Кодексийн 36 зүйлийн хэрэгжилтийн асуумж, компаниудаас ирүүлсэн тайлан, хавсаргасан нотлох баримт болон Хорооноос хийсэн хянан баталгаажуулалтын үр дүнд үндэслэн гаргажээ.

Мөн тайлангаа шинэчлэн ирүүлсэн 40 компанид давтан үнэлгээ хийж, зөвлөмж, чиглэлийн хэрэгжилт бодит ахиц өгсөн эсэхийг үнэлсэн нь судалгааны практик ач холбогдлыг нэмэгдүүлж байна.

Нэгдсэн дүнгээр 112 компанийн Кодексийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 61.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар буурсан байна. Тодруулбал, 2025 онд үнэлгээнд төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх), түүний дэргэдэх хороодын тайлагнал, гүйцэтгэлийн үнэлгээ, ТУЗ–ийн дарга, гишүүдийн хараат бус байдал, хүйсийн харьцаа, хороодын дарга нарт тавигдах шаардлага зэрэг нийт 7 нэмэлт тохируулга оруулснаар комплайнсын хяналт, компаниудын засаглалын бодит хэрэгжилтийг илүү өндөр босгоор хэмжих болсон нь дундаж үнэлгээнд нөлөөлжээ.

Харин тайлангаа шинэчлэн ирүүлж, хугацаатай чиглэл, зөвлөмжийн дагуу сайжруулалт хийсэн 40 компанийн давтан үнэлгээний дундаж 78.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өссөн нь зохицуулагч байгууллагын зөвлөмж, компанийн өөрийн засаглалын сайжруулалтын ажил бодит үр дүнтэй байгааг харуулж байна.

ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

Виртуал хөрөнгөө түгжих

Staking

Стейкинг гэдэг нь блокчэйний үйл ажиллагааг дэмжих зорилгоор виртуал хөрөнгийг тодорхой хугацаанд түгжих явдал юм. Криптогоо түгжсэний хариуд виртуал хөрөнгө урамшуулал болгон авна.



Виртуал хөрөнгөө хадгалах

HODL

Виртуал хөрөнгийг худалдаж аваад зах зээл тогтворгүй болох эсхүл ханш нь унах үед зарахгүйгээр тодорхойгүй хугацаагаар хадгалах гэсэн утгатай крипто хэллэг

Эх сурвалж: Эдийн засаг,
санхүүгийн нэр томъёоны
тайлбар толь

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ БА БОДЛОГЫН ЧИГЛЭЛ

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар нь хотжилт, хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээл болон иргэдийн өмчийн харилцаатай шууд холбоотой эдийн засгийн чухал салбарын нэг юм. Монгол Улсад сүүлийн жилүүдэд орон сууцны болон арилжааны зориулалттай үл хөдлөх хөрөнгийн эрэлт нэмэгдэхийн зэрэгцээ зуучлалын үйлчилгээний зах зээл өргөжин хөгжиж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2020 оноос хойш тус салбарыг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон түүнтэй уялдан гарсан хэм хэмжээний актуудын хүрээнд хянан зохицуулж ирсэн. Энэ хугацаанд тусгай зөвшөөрөл олгох, салбарын оролцогчдын тохиромжтой байдлыг үнэлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагыг хэрэгжүүлэх, хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах зэрэг ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн нь салбарын зохицуулалтын орчныг тодорхой хэмжээнд бэхжүүлсэн юм. Гэсэн хэдий ч өнөөгийн нөхцөлд салбарын үйл ажиллагаа журам болон ерөнхий хууль тогтоомжид тулгуурлан зохицуулагдаж байгаа нь урт хугацаанд тогтвортой, нэгдсэн бодлого хэрэгжүүлэхэд хүндрэлтэй хэвээр байна.

Иймд зах зээлийн оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг нэг мөр тодорхойлох, хөрөнгө оруулагч болон үйлчлүүлэгчийн эрх ашгийг үр нөлөөтэй хамгаалах, мэдээллийн ил тод, нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, цахим зуучлалыг зохицуулах, мөнгө угаахтай тэмцэх тогтолцоог олон улсын стандарттай нийцүүлэн баталгаажуулахад бие даасан хууль эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлага тулгарч байна.



ФАТФ-аас 2028 онд Монгол Улсад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр дараагийн харилцан үнэлгээг эхлүүлэхээр товлогдсон бөгөөд уг үнэлгээнд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын эрх зүйн зохицуулалт, хяналт, хэрэгжилт нь чухал шалгууруудын нэг болно. Иймд тус салбарыг ашиглан мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулах, олон улсын стандартын шаардлагыг тогтвортой хангах, өмнөх ахиц дэвшлийг хадгалах, улмаар Монгол Улсыг дахин саарал жагсаалтад орох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын тухай бие даасан хуулийг цаг алдалгүй батлан хэрэгжүүлэх нь нэн чухал.

Санхүүгийн зохицуулах хороонд 2026 оны I улирлын байдлаар 298 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага бүртгэлтэй бөгөөд тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд 312 брокер, 1388 агенттайгаар үйл ажиллагаа явуулж байна. Дээрх статистикаас үзвэл үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар нь хөдөлмөр эрхлэлтийн, эдийн засгийн идэвхтэй оролцогч болохыг харуулж байна.

Төрийн байгууллагаас өнгөрөгч хугацаанд тус салбарын цар хүрээг тодорхойлох, статистик мэдээллийг бүрдүүлэх, бүртгэлжүүлэх, мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулах чиглэлд төвлөрөн ажилласан бол цаашид салбарыг бодлого зохицуулалтын хувьд дараагийн түвшинд хүргэхийг зорин ажиллаж байна.

Энэ хүрээнд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хянан зохицуулж буй төрийн байгууллагын эрх зүйн байдал, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын жишиг, туршлагатай харьцуулан судлах, холбогдох төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоог сайжруулах, салбарын хамрах хүрээ, нэр томъёог тодорхойлох ажлыг хэрэгжүүлж байна. Мөн “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын олон улсын хууль, эрх зүйн орчны судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварыг батлуулан холбогдох ажлуудыг эхлүүлээд байна.

Цаашид үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын бодлого дараах үндсэн чиглэлүүдэд төвлөрч ажиллана. Үүнд:

Нэгдүгээрт, олон улсын жишигт нийцсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, брокер, агентын үйл ажиллагаанд тавих стандарт, ёс зүй, хариуцлагын механизмыг тодорхой болгох, Хоёрдугаарт, салбарын мэдээллийн нэгдсэн сан, ил тод байдлыг нэмэгдүүлж, үл хөдлөх зуучлалтай холбоотой бүхий л статистикийг бодит цагийн горимоор нээлттэй болгож, цахимжуулах, гуравдугаарт, мэргэжлийн хүний нөөцийг чадавхжуулах, тасралтгүй сургалтын тогтолцоог хөгжүүлэх .

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, ил тод байдлыг хангах, мэргэжлийн стандартыг тогтоох зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх нь зөвхөн нэг салбарын хөгжлийг дэмжээд зогсохгүй, Монгол Улсын макро эдийн засгийн тогтвортой байдал, санхүүгийн зах зээлийн аюулгүй байдлыг хангахад чухал нөлөө үзүүлэх бодлогын алхам юм. Цаашид төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын түншлэлд тулгуурласан урт хугацааны цогц бодлогыг хэрэгжүүлж, цахим шилжилт болон хүний нөөцийн чадавхыг тасралтгүй бэхжүүлснээр тус салбар нь эдийн засгийн ил тод байдлыг хангах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалсан, итгэлцэл бүхий тогтолцоо болон хөгжих боломжтой юм.



ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

НОГООН САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хороо нь Олон улсын Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI), Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (ACCU)–той хамтран “Хадгаламж, зээлийн хоршооны гишүүн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан хүртээмжтэй ногоон санхүүжилт” төслийг хэрэгжүүлж эхэллээ. Төсөл нь бичил болон жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан хадгаламж, зээлийн хоршооны ногоон зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, ногоон санхүүжилтийн ач холбогдлыг хоршоодод таниулан сурталчлах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой юм.

Хадгаламж, зээлийн хоршоодоос авсан судалгааны үр дүнд үндэслэн Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбооны техникийн баг Монгол Улсын нөхцөл, онцлог тохирсон арга зүй болон зургаан төрлийн ногоон санхүүгийн бүтээгдэхүүний саналыг боловсруулж, туршин нэвтрүүлэхэд бэлэн болоод байна. Мөн хадгаламж, зээлийн хоршоодын ногоон зээлийн ангилал, төрлийг бий болгох, бүтээгдэхүүнийг турших бэлтгэл хангах, орон нутгийн хоршоод болон гишүүдийн ногоон санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Тогтвортой ногоон санхүүгийн бүтээгдэхүүнийг турших нь” сургалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулж байна.

Эхний сургалтыг Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо болон Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоотой хамтран Ховд аймагт зохион байгууллаа. Сургалтад баруун бүсийн зургаан аймгийн 33 хадгаламж, зээлийн хоршооны төлөөлөл, “The Nature Conservancy (TNC)” байгууллагын бүсийн болон төв оффисын зөвлөхүүд, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)–ийн орон нутгийн төлөөлөл зэрэг нийт 81 хүн оролцов.

Сургалтын үеэр хадгаламж, зээлийн хоршоодын гишүүд байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тогтвортой санхүүгийн шийдлийг хөгжүүлэх, байгальд ээлтэй хөрөнгө оруулалтыг дэмжих, урамшуулах, ногоон санхүүжилтийн бодлого болон үр нөлөөний судалгаа, үнэлгээ хийх чиглэлээр санал солилцож, туршлагаа хуваалцлаа.

Энэхүү төсөл нь хадгаламж, зээлийн хоршоодоор дамжуулан орон нутгийн иргэд, тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчдийн хүртээмжтэй ногоон санхүүжилтэд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

“INVEST MONGOLIA: ENERGY & FINANCE” ФОРУМ ТОКИО ХОТНОО ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Япон Улсын Токио хотноо “Invest Mongolia: Energy and Finance” бизнес форум амжилттай зохион байгуулагдлаа. Тус форумыг Монгол Улсын Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол Улсын Хөрөнгө оруулалт, худалдааны газар, Япон Улсын Гадаад худалдааны байгууллага (JETRO), Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яам хамтран зохион байгуулав. Форумын нээлтийн үйл ажиллагаанд Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Б.Баярсайхан, Японы Улсын Гадаад худалдааны байгууллагын дарга Норихико Ишигүро болон хоёр улсын төр, хувийн хэвшлийн төлөөлөл оролцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц

нээлтийн үеэр хэлсэн үгэндээ дэлхийн эдийн засаг, худалдаа, санхүүгийн зах зээлд тодорхойгүй байдал үргэлжилж буй хэдий ч Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлт тогтвортой өсөлттэй байна. Тодруулбал, 2025 онд Монгол Улсын эдийн засаг 6.8 хувиар өссөн бөгөөд үүнд хөдөө аж ахуйн салбарын сэргэлт, уул уурхайн салбарын өндөр гүйцэтгэл голлон нөлөөлснийг онцолсон юм.

Мөн Улсын Их Хурал, Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг дэмжих, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах бодлогын арга хэмжээг үе шатай хэрэгжүүлж байгааг дурдаад Санхүүгийн зохицуулах хороо мөн санхүүгийн салбарын эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хүртээмжтэй, олон тулгуурт санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж байгааг онцоллоо. Эдгээр бодлого, зохицуулалтын үр дүнд санхүүгийн салбарын нийт хөрөнгө 2020 онтой харьцуулахад хоёр дахин өсөж, 2025 оны жилийн эцсийн байдлаар ДНБ-ий 26.8 хувьтай тэнцсэн болохыг дурдсан юм. Түүнчлэн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 14 их наяд төгрөгт хүрч, сүүлийн таван жилд тав дахин өссөн бол үнэт цаасны арилжааны хэмжээ 1.3 их наяд төгрөгт хүрч, 2020 онтой харьцуулахад 20 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Цаашид ч санхүүгийн салбарын өсөлт, хөгжлийг бэхжүүлж зах зээлийн тогтвортой байдлыг хадгалах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг арвижуулж салбарыг хөгжлийг шинэ шатанд гаргах бодлогыг Санхүүгийн зохицуулах хороо тууштай хэрэгжүүлнэ гэдгийг онцолсон юм.

Форумын хүрээнд Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлага, хөрөнгийн зах зээлийн боломж, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг танилцуулж, Японы хөрөнгө оруулагчидтай санал солилцов. Мөн эрчим хүч, санхүүгийн салбар дахь хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын боломж болон хоёр улсын бизнес, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар төр, хувийн хэвшлийн төлөөлөл оролцсон салбар хэлэлцүүлгүүдийг зохион байгууллаа. Япон Улсын төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагч байгууллагуудын 240 гаруй төлөөлөгч хүрэлцэн ирж, Монголын хувийн хэвшлийн 14 аж ахуйн нэгж үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрөө танилцуулан, Японы бизнесийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай бизнесийн харилцаа холбоо тогтоох, хамтын ажиллагааны боломжийн талаар санал солилцлоо.

Тус форум нь Монгол, Японы санхүү, хөрөнгө оруулалт, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, Японы хөрөнгө

оруулагчдад Монгол Улсын зах зээлийн боломжийг танилцуулах ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

МОНГОЛ, ЯПОНЫ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ШИНЭ ТҮВШИНД ХҮРГЭХЭЭР САНАЛ НЭГДЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц



Япон Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагын удирдлагуудтай уулзалт хийж, хоёр байгууллагын хамтын ажиллагааны үр дүн, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

Уулзалтад тус байгууллагын дарга Ито Ютака, Олон улсын асуудал эрхэлсэн дэд дарга Озаки Юү, Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Б.Баярсайхан болон албаны бусад хүмүүс оролцсон бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц уулзалтын эхэнд Монгол Улсын санхүүгийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах, туршлага судлуулах сургалт, хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлж ирсэнд талархал илэрхийллээ. Үүний дараа Монгол Улсын санхүүгийн салбарыг олон тулгуурт, хүртээмжтэй, ухаалаг, ногоон санхүүгийн тогтолцоонд шилжүүлэх хүрээнд хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээнийхээ талаар танилцуулсан юм. Салбарын хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний 26.8 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлийн хөгжил эрчимжиж, зах зээлийн үнэлгээ 13.9 их наяд төгрөгт, үнэт цаасны арилжааны хэмжээ 1.3 их наяд төгрөгт хүрснийг онцлов. Үүний



зэрэгцээ хадгаламжийн сертификат, тогтвортой байдлын бонд зэрэг шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж, виртуал хөрөнгийн үйлчилгээ болон сэндрбоксын зохицуулалтыг хэрэгжүүлж, блокчэйн суурьтай арилжааны системийг туршин нэвтрүүлснээр санхүүгийн үйлчилгээний хүртээмж, шуурхай байдал нэмэгдэж байгааг танилцууллаа. Мөн JICA-тай хамтран хэрэгжүүлсэн “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх” хоёр үе шаттай төслийн үр дүнг танилцууллаа. Төслийн хүрээнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх, IPO гаргах компаниудад зөвлөгөө өгөх, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан. Мөн биржийн бус зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлж, компанийн хаалттай бондын зохицуулалтыг боловсронгуй болгосноор үнэт цаас гаргах үйл ажиллагааны хугацаа, зардлыг бууруулж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдад чиглэсэн зах зээлийн хөгжлийн суурийг бүрдүүлснийг онцоллоо.

Уулзалтын төгсгөлд талууд Монгол Улсын санхүүгийн зах зээлийг тогтвортой, хүртээмжтэй байдлаар хөгжүүлэх, үнэт цаасны санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх, урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэхийн зэрэгцээ аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын итгэлийг бэхжүүлэх, компанийн бондын зах зээлийг хөгжүүлэх хүрээнд бондын батлан даалтын санг нэвтрүүлэх чиглэлд хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр санал нэгдсэн юм.

Японы санхүүгийн зохицуулагч байгууллага нь банк, даатгал, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг зохицуулж, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах үүрэгтэй төрийн байгууллага юм.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ХОЁР ДАХЬ ETF-ИЙН АРИЛЖАА ЭХЭЛЛЭЭ



“Би Би Эс Эй” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Гоулд траст хамтын биржээр арилжаалагддаг ХОС” ХХК-ийн сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх

ёслол 2026 оны 5 дугаар сарын 14-ний өдөр боллоо. Ёслолд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат, “Би Би Эс Эй ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Батаа болон холбогдох албаны хүмүүс оролцов.

Арга хэмжээг нээж Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал хэлэхдээ, хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо холбогдох журмуудыг шинэчлэн баталж, биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан буюу ETF (Exchange Traded Fund)-ийн зохицуулалтын орчныг бүрдүүлснийг онцоллоо.

Тэрбээр, энэхүү шинэ зохицуулалт нь хөрөнгийн зах зээлд олон улсын жишигт нийцсэн шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог тэлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах чухал ач холбогдолтойг тэмдэглэв. Мөн 2023 онд анхны биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн тусгай зөвшөөрлийг “Инвескор глобал кью хамтын биржээр арилжаалагддаг ХОС” ХХК-д олгосон бол “Гоулд траст хамтын биржээр арилжаалагддаг ХОС” ХХК нь Монголын хөрөнгийн зах зээл дэх хоёр дахь ETF болж байгааг дурдлаа.

“Гоулд траст” сан нь алтанд суурилсан ETF гэдгээрээ онцлог бөгөөд хөрөнгө оруулагчдад алтны үнийн өсөлт, бууралтаас өгөөж хүртэх боломжийг хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан олгож буй юм. Ингэснээр хөрөнгө оруулагчид хувьцаа худалдан авч буйтай адил хэлбэрээр хөрөнгийн биржээр дамжуулан ETF-ийн нэгж эрх худалдан авч, нэмэлт зардалгүйгээр алтанд хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэж байна. Тус сангийн суурь хэрэгсэл болох GLD буюу SPDR Gold Shares ETF нь 2004 оны 11 дүгээр сараас хойш Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж буй алтны ETF юм. Энэ нь дотоодын хөрөнгө оруулагчдад зөвхөн Монголын зах зээлээр хязгаарлагдахгүйгээр олон улсын зах зээлд арилжаалагддаг санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулж, багцаа төрөлжүүлэх боломжийг нээж байгаагаараа ач холбогдолтой.

ЯРИЛЦЛАГА

ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН САНХҮҮЖИЛТИЙН КОД НЬ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ӨГӨГДӨЛД СУУРИЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ ОЛГОХОД ЧИГЛЭНЭ

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийн түвшин харьцангуй өндөр гэж үнэлэгддэг. Тэгвэл санхүүгийн хүртээмж дэх жондөрийн ялгаа ямар түвшинд байна вэ?

Монгол Улс санхүүгийн хүртээмжийн хувьд олон улсын түвшинд харьцангуй сайн үзүүлэлттэй орнуудын нэгт тооцогддог. Дэлхийн банкны судалгаагаар Монгол Улс санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтээр дэлхийд 9 дүгээрт эрэмбэлэгдэж, насанд хүрсэн хүн амын 98.9 хувь нь санхүүгийн үйлчилгээ авдаг гэсэн үзүүлэлттэй байна. Энэ нь манай улсын санхүүгийн систем өргөн хүрээнд иргэдэд хүрч чадсаныг харуулж буй юм.

Монгол Улсын онцлог бол газар нутгийн хувьд өргөн уудам, хүн амын нягтаршил багатай, нүүдлийн ахуй уламжлалтай хэдий ч санхүүгийн үйлчилгээ цахим сувгаар дамжин иргэдэд хүрч, алслагдсан орон нутагт амьдарч буй иргэд гар утас, интернэт ашиглан төлбөр тооцоо хийх, зээл авах, хадгаламж нээх зэрэг санхүүгийн үйлчилгээг цахимаар авч байна.

Хувь хэрэглэгчийн түвшинд авч үзвэл Монгол Улсад санхүүгийн үндсэн үйлчилгээний хүртээмжид эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хооронд зөрүү ажиглагддаггүй. Данс эзэмшилт, төлбөрийн үйлчилгээ ашиглалт, зээл, хадгаламж зэрэг санхүүгийн үйлчилгээний хувьд эмэгтэй мөн адил ялгаа байхгүй.

Гэхдээ санхүүгийн үйлчилгээнд “хандах боломжтой байх” нь санхүүгийн бодит эрх тэгш байдал бүрэн хангагдсан гэсэн үг биш. Хүн бүр данстай байх, цахим төлбөр ашиглах боломжтой байх нь эхний алхам. Харин тухайн иргэн, өрх, бизнес өөрийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээ авч чадаж байна уу, санхүүжилтийн хэмжээ нь хүрэлцээтэй байна уу, нөхцөл нь шударга байна уу, эрсдэлийн үнэлгээ нь ялгаварлалгүй байна уу гэдэг нь илүү гүнзгий асуудал юм.

Иймээс сүүлийн жилүүдэд бид санхүүгийн хүртээмжийг зөвхөн “хэдэн хүн санхүүгийн үйлчилгээ авч байна вэ?” гэдэг тоон үзүүлэлтээр бус, “хэн ямар чанартай, ямар

нөхцөлтэй, ямар үр дүнтэй санхүүгийн үйлчилгээ авч байна вэ?” гэдэг чанарын өнцгөөс харах шаардлагатай болж байна.

Санхүүгийн хүртээмжийн асуудлыг эмэгтэй бизнес эрхлэгчдийн түвшинд авч үзвэл ямар ялгаа харагддаг вэ?

Монгол Улсад эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн оролцоо өндөр, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байдаг. Гэсэн хэдий ч бизнесээ өргөжүүлэх, хөрөнгө оруулалт татах, эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх шатанд эмэгтэй бизнес эрхлэгчид санхүүжилтийн тодорхой хүндрэлүүдтэй тулгарсаар байна.

Олон улсын болон дотоодын туршлагаас харахад эмэгтэй бизнес эрхлэгчдийн өмнө тулгардаг нийтлэг саад нь зөвхөн зээл олгогдох эсэх асуудал биш юм. Харин санхүүжилтийн хэмжээ, барьцаа хөрөнгийн шаардлага, зээлийн хугацаа, хүүгийн нөхцөл, бизнесийн бүртгэл, санхүүгийн тайлангийн чанар, зээлийн түүх, мөн тухайн бизнесийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээ байгаа эсэхтэй холбоотой байдаг.

Манай улсын хувьд бизнесийн зээлийн хүртээмжийг илүү нарийвчлан харахад эмэгтэй бизнес эрхлэгчдийн авч буй санхүүжилтийн хэмжээ бусад бизнесийнхтэй харьцуулахад бага байгаа нь анхаарах асуудал юм. Тухайлбал, статистик мэдээллээр бизнес эрхлэгчдэд олгогдож буй зээлийн тооны хувьд хүйсийн ялгаа ажиглагдахгүй олгогдож буй зээлийн дундаж хэмжээ нь бусад бизнесийнхээс ойролцоогоор 1.5 дахин бага байна.

Мөн асрахуйн хөдөлмөрийн ачаалал эмэгтэйчүүдэд илүү ногддог нь бизнесээ өргөжүүлэх, санхүүгийн байгууллагатай харилцах, сургалт мэдээлэлд хамрагдах, эрсдэл хүлээж хөрөнгө оруулах шийдвэр гаргахад нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, санхүүжилтийн ялгаа нь дан ганц санхүүгийн салбарын асуудал биш, хөдөлмөр эрхлэлт, өмчлөл, өрхийн үүрэг хариуцлага, бизнесийн албан ёсны байдал зэрэг олон хүчин зүйлтэй огтлолцдог.

Тиймээс эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд зөвхөн “зээл олгох” гэж нарийн утгаар нь харах бус, тэдний хэрэгцээ шаардлагыг судлах, олгогдож буй санхүүгийн бүтээгдэхүүнүүдийн хувьд мэдэгдэхүйц ялгаа буй эсэхийг үнэлэх, өгөгдөлд суурилсан бодлого гаргах хэрэгцээ бий. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо өнгөрсөн жилээс эхлэн “Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн код (WeCode)” олон улсын санаачилгад нэгдэн ажиллаж байна.

Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн код, түүний ач холбогдлыг тайлбарлаж өгнө үү?

Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн код нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн салбарт жендерийн мэдрэмжтэй бодлого, бүтээгдэхүүн, өгөгдлийн тогтолцоог хөгжүүлэх зорилготой олон улсын санаачилга юм. Энэхүү санаачилга нь 2023 онд Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн жилийн уулзалтын үеэр олон улсын түвшинд зарлагдсан бөгөөд Дэлхийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын хөгжлийн түнш байгууллагууд дэмжин хэрэгжүүлж байна.

Кодын гол ач холбогдол нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн асуудлыг зөвхөн нэг удаагийн төсөл, хөнгөлөлттэй зээлийн арга хэмжээ төдий бус, санхүүгийн системийн түвшний өөрчлөлт болгон авч үзэж байгаад оршино. Өөрөөр хэлбэл, код нь санхүүгийн байгууллагууд, зохицуулагчид, бодлого тодорхойлогчид, хөгжлийн байгууллагуудыг нэг зорилгын дор нэгтгэж, эмэгтэй бизнес эрхлэгчдэд чиглэсэн санхүүжилтийг илүү системтэй, хэмжигдэхүйц, хариуцлагатай болгох механизм юм.

Кодын хүрээнд улс орнууд хэд хэдэн чиглэлд анхаарч ажилладаг. Нэгдүгээрт, эмэгтэй бизнес эрхлэгчдийг тодорхойлох нэгдсэн ойлголт, ангилал бий болгох. Хоёрдугаарт, санхүүгийн байгууллагууд хүйсээр ангилсан өгөгдөл цуглуулах, тайлагнах тогтолцоог бүрдүүлэх. Гуравдугаарт, эдгээр өгөгдөлд үндэслэн бодлого, бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх. Дөрөвдүгээрт, олон улсын сайн туршлага, техникийн туслалцаа, санхүүжилтийн эх үүсвэртэй холбогдох боломжийг нэмэгдүүлэх.

Монгол Улс энэхүү кодоод нэгдсэнээр эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн асуудлыг бодит өгөгдөл, нэгдсэн тодорхойлолт, санхүүгийн байгууллагуудын

амлалт, бодлогын уялдаа холбоотойгоор шийдвэрлэх боломж бүрдэж байна. Энэ нь олон улсын хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, техникийн болон санхүүгийн дэмжлэг татах, бүс нутгийн сайн туршлагаас суралцах чухал суурь болно.

Товчхондоо, код нь эмэгтэй бизнес эрхлэгчдэд “санхүүжилт олгоё” гэсэн ерөнхий уриалга биш, харин хэн санхүүжилт авч байна, ямар нөхцөлтэй авч байна, ямар хэрэгцээ хангагдахгүй байна, санхүүгийн байгууллагууд ямар өөрчлөлт хийх ёстой вэ гэдгийг өгөгдөлд суурилан тодорхойлох бодлогын механизм юм.

Кодоод нэгдсэнээр Санхүүгийн зохицуулах хороо ямар үүрэг хүлээж, ямар ажлууд төлөвлөж байна вэ?

Санхүүгийн зохицуулах хорооны хувьд энэхүү кодоод нэгдсэнээр зохицуулалтын салбарын хэмжээнд эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах, хүйсээр ангилсан өгөгдөл, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, санхүүгийн байгууллагуудыг илүү жендерийн мэдрэмжтэй бодлого, бүтээгдэхүүн хөгжүүлэхэд чиглүүлэх үүрэгтэй оролцож байна.

Юуны өмнө хамгийн чухал ажил бол “эмэгтэй бизнес эрхлэгч” гэсэн нэгдсэн тодорхойлолт, ангиллыг бий болгох явдал юм. Өнөөдрийн байдлаар манай улсад эмэгтэй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчийг тодорхойлох нэгдсэн тодорхойлолт, санхүүгийн салбарын хэмжээнд ашиглах нэгдсэн өгөгдлийн стандарт бүрэн төлөвшөөгүй байна. Үүнээс шалтгаалан банк, санхүүгийн байгууллага, статистикийн байгууллага, бизнесийн бүртгэлийн мэдээлэл хоорондоо бүрэн нийцэхгүй байх сорилт тулгардаг.


Иймд Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанк хамтран “Эмэгтэй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн таксономи боловсруулах” чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Мөн Хороо зохицуулалтын салбарын байгууллагуудыг кодоод идэвхтэй хамруулахад анхаарч байна. Өнөөдрийн байдлаар 28 банк бус санхүүгийн байгууллага болон 4 мэргэжлийн холбоо кодоод нэгдэж, эмэгтэй бизнес эрхлэгчдэд чиглэсэн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх, санхүүгийн үйлчилгээний мэдээллийг хүйсээр ангилан бүртгэх, дотоод бодлого, стратегидаа жендерийн зорилтыг тусгах чиглэлээр тодорхой амлалт өгөөд байна. Энэ нь зах зээлийн оролцогчид энэ асуудлыг зөвхөн нийгмийн хариуцлагын хүрээнд бус, бизнесийн болон бодлогын чухал чиглэл гэж харж эхэлж байгаагийн илрэл юм.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ТОГТВОРТОЙ БОНДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН 2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЭЛ


Дэлхийн Банкны Санхүүгийн Тогтвортой Хөтөлбөрийн хүрээнд тогтвортой бондын зах зээлийн чиг хандлага тайланг 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар хүргэж байна. Тогтвортой бондын зах зээлийн голлох бүтээгдэхүүн болох ногоон бонд, нийгмийн бонд, тогтвортой байдлын бонд, тогтвортой байдалтай уялдсан бонд, шилжилтийн бондын нийт хуримтлагдсан хэмжээ 2026 оны 03 дугаар сарын байдлаар 7.25 их наяд ам.долларт хүрсэн байна. 2026 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл өндөр байсан бөгөөд нийт 270 тэрбум ам.долларын бонд гарсан байна. Ногоон бонд нь нийт гаргасан бондын 64%-ийг бүрдүүлж байгаа бөгөөд хамгийн түгээмэл бонд хэвээр байна.

Зураг. Тогтвортой бондын гаргалт /тэрбум ам.доллар/




Source: World Bank based on Environmental Finance Data

Зураг. Зах зээл болон бондын төрлөөр ангилсан тогтвортой бондын нийт хуримтлагдсан дүн /тэрбум ам.доллар/



Source: World Bank based on Environmental Finance Data

Зураг. Зах зээл болон бонд гаргагчийн төрлөөр ангилсан тогтвортой бондын хуримтлагдсан дүн /тэрбум ам.доллар/




Source: World Bank based on Environmental Finance Data

Хөгжиж буй улс орнуудын тогтвортой бондын гаргалт нийт бондын 15%-ийг бүрдүүлж байна. Ногоон бондын гаргалт нь хөгжиж буй улс орнуудын зах зээл болон хөгжингүй зах зээлүүдэд (AM) хоёуланд нь давамгайл байж, тус бүр нийт хуримтлагдсан дүн 67% болон 66%-ийг эзэлж байна. Ногоон бонд нь хөгжиж буй зах зээл болон хөгжингүй зах зээлийн аль алинд давамгайл байгаа бөгөөд хуримтлагдсан нийт гаргалтын 67 хувийг хөгжиж буй зах зээлд, 69 хувийг хөгжингүй зах зээл тус тус бүрдүүлжээ. Харин засгийн газар, төрийн агентлаг, хот, орон нутаг болон бүс нутгийн захиргааны байгууллагуудын гаргалтыг хамруулан авч үзвэл, хөгжиж буй зах зээлийн нийт гаргалтын 25 хувийг эзэлж байгаа бол хөгжингүй зах зээлд энэ үзүүлэлт 43 хувьтай байна

2026 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл:

2026 оны 1 дүгээр улиралд тогтвортой бондын нийт хуримтлагдсан гаргалт 270 тэрбум ам.доллар болж, 2025 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад 10.7 хувиар буурсан ч 2025 оны 4 дүгээр улиралтай харьцуулахад 28.7 хувиар өссөн байна. Бондын төрлөөр авч үзвэл, ногоон бондын гаргалт 2025 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад 3.7 хувиар, нийгмийн бонд 2.6 хувиар, шилжилтийн бонд 32.9 хувиар тус тус өсжээ. Харин тогтвортой хөгжлийн бонд болон тогтвортой байдалтай уялдсан бондын гаргалт өмнөх оны мөн үеэс бараг хоёр дахин буурч, тус бүр 47.7 хувь болон 43.4 хувиар агшсан байна. Зах зээлийн ангиллаар авч үзвэл, хөгжингүй зах зээлүүдийн гаргалт 2025 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад 15.8 хувиар өссөн бол хөгжиж буй зах зээлүүдийн гаргалт 30.7 хувиар буурсан байна.

Зураг. Бонд гаргагчийн төрлөөр ангилсан тогтвортой бондын улирлын гаргалт /тэрбум ам.доллар/



Source: World Bank based on Environmental Finance Data

Эх сурвалж: World Bank. (2026). Labeled sustainable bonds: Quarterly market update (Q1). World Bank Group

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТ: НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН 2025 ОНЫ ТӨЛӨВ

2025 оны нэгдсэн судалгаагаар нээлттэй хувьцаат компаниудын ТУЗ-ийн үр нөлөө, ил тод байдал болон зах зээлийн үнэлгээний хамаарлыг тодорхойлов.

Судалгаагаар хөрөнгийн биржийн бүртгэлийн ангилал, зах зээлийн үнэлгээ болон компанийн засаглалын үнэлгээний хооронд тодорхой хамаарал ажиглагджээ.

Тайлангаа шинэчлэн ирүүлсэн компаниудын хувьд I ангиллын компанийн үнэлгээ өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар, II ангиллынх 3.6 хувиар, III ангиллынх 6.1 хувиар тус тус өссөн байна. Ялангуяа I ангиллын компаниуд компанийн соёлыг төлөвшүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрхийг тэгш хангах, эрсдэлийн удирдлагыг зохистой зохион байгуулах, оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах чиглэлээр харьцангуй сайн үнэлгээ авчээ.

Кодексийн 9 зарчмын хэрэгжилтээс харахад компанийн соёл, хувьцаа эзэмшигчдийн эрх, эрсдэлийн удирдлага, аудит-хяналтын тогтолцоо, тайлагнал, мэдээллийн ил тод байдлын чиглэлүүд харьцангуй сайн үнэлгээтэй байна. Харин хамгийн их анхаарал шаардсан хэсэг нь ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа байв. Зарим компанийн хувьд ТУЗ жилийн ажлын гүйцэтгэлээ үнэлдэггүй, хороод тайлангаа тогтмол гаргадаггүй, хороодын дарга, гишүүдийн хараат бус байдал болон үүргийн хуваарилалт хангалтгүй байгаа нь нийт үнэлгээнд сөргөөр нөлөөлжээ. ТУЗ бол компанийн стратеги, эрсдэл, хяналт, гүйцэтгэх удирдлагын хариуцлагыг зангидах гол төв. ТУЗ бодитой ажиллахгүй бол сайн бодлого цаасан дээр үлдэж, тайлан хэлбэр төдий болох эрсдэлтэй. Тиймээс ТУЗ-ийн ажлын төлөвлөлт, хороодын тайлагнал, гишүүдийн гүйцэтгэлийн үнэлгээ, хараат бус байдлын шаардлага нь компанийн засаглалын дараагийн шатны үндсэн шалгуур болж байна.

Ил тод байдлын хувьд компаниудын цахим хуудсанд нийтэд ил болгох шаардлагатай мэдээлэл мөн онцгой ач холбогдолтой. Санхүүгийн тайлан, санхүүгийн бус мэдээлэл, алсын хараа, зорилго, бүтээгдэхүүн үйлчилгээ, бодлогын баримт бичиг, дотоод дүрэм журам зэрэг мэдээлэл нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, олон нийтэд анхан шатны эх сурвалж болдог. Өнөөдөр хөрөнгө оруулагч компанийн хаалгыг татахаасаа өмнө цахим хуудсыг нь нээдэг болсон. Тэнд мэдээлэл байхгүй бол итгэл үүсэхгүй, харин мэдээлэл бүрэн, ойлгомжтой, тогтмол шинэчлэгддэг бол компанийн засаглалын соёл бодитоор харагдана.

Судалгаа нэг зүйлийг тодорхой харуулж байна. Кодексийн хэрэгжилтийг зөвхөн тайлагнах бус, бодитоор хэрэгжүүлж эхэлсэн компаниудын үнэлгээ ахиж байна. Харин нийт компаниудын хувьд ТУЗ-ийн үр нөлөө, дэргэдэх хороодын ажиллагаа, ил тод тайлагнал, бодлогын баримт бичгийн хэрэгжилт жигд түвшинд хүрээгүй хэвээр байна.

Цаашид Кодексийн хэрэгжилт нь нь зөвхөн зохицуулагчийн шаардлага биелүүлсэн эсэхийг хэмжих хэрэгсэл бус, хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалт, компанийн зах зээлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлага, урт хугацааны тогтвортой өсөлтийн бодит үзүүлэлт болж төлөвших шаардлагатай. Зохистой засаглал бол нэг удаагийн тайлан биш. Энэ бол ТУЗ-ийн өдөр тутмын хариуцлага, удирдлагын сахилга бат, ил тод байдлын соёл, хөрөнгө оруулагчтай байгуулж буй итгэлийн гэрээ юм.

Дэлгэрэнгүй тайлантай танилцах: Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт – 2025 он

<https://www.frc.mn/resources/Image/Document/202605/N0sUV/2025-%D0%BE%D0%BD%D1%8B-%D0%B6%D0%B8%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%8D%D1%86%D1%8D%D1%81-%D1%85%D1%83%D0%B2%D1%8C%D1%86%D0%B0%D0%B0%D1%82-%D0%BA%D0%BE%D0%BC%D0%BF%D0%B0%D0%BD%D0%B8-05-22.pdf>

ФИНТЕК БА РЕГТЕК

САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН КОМПАНИУД

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт санхүүгийн үйлчилгээний салбарын аюулгүй байдлыг хамгаалахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэж буй дэлхийн шилдэг кибер аюулгүй байдлын компаниудыг онцлон хүргэж байна.

Хиймэл оюун ухаан (AI)-ы хөгжил залилан, хулгай болон мэдээлэл алдагдах эрсдэлийг улам нэмэгдүүлж буй энэ үед санхүүгийн үйлчилгээний салбар кибер халдлагад бараг цаг тутам өртөж байна. 2025 онд хэд хэдэн томоохон кибер халдлага гарсан бөгөөд үүний нэг нь Lazarus Group-ийн Bybit платформд үйлдсэн халдлага байв. Уг халдлагын үеэр 1.5 тэрбум ам.долларын үнэ бүхий Ethereum хулгайлагдсан. Мөн Global Bank Network-ийн нийлүүлэлтийн сүлжээний халдлагын улмаас зөвшөөрөлгүй гүйлгээнүүд хийгдэж, олон сая ам.долларын хохирол учирсан байна. Түүнчлэн MegaCorp-ын мэдээллийн сан алдагдсанаар 20 сая хэрэглэгчийн зээлийн карт болон хувийн мэдээлэл ил болсон юм.

Ийм нөхцөлд санхүүгийн байгууллагууд кибер аюул заналтай тэмцэхийн зэрэгцээ хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэт хамгаалалтын шийдлүүдийг нэвтрүүлж, сүлжээ болон өгөгдлийн аюулгүй байдлаа шинэ түвшинд хүргэх шаардлагатай болжээ. Энэхүү мэдээллийг Fintech magazine-аас эрхлэн гаргадаг ШИЛДЭГ 10 нийтлэлийн хүрээнд бэлтгэв.



10. Trend Micro



Үүсгэн байгуулагдсан он: 1998

Төв байр: Токио, Япон / Техас, АНУ

Гүйцэтгэх захирал: Eva Chen

Trend Micro нь орчин үеийн үүлэн технологид суурилсан системүүд болон олон жилийн турш ашиглагдаж буй банкны үндсэн дэд бүтцийг зэрэг хамгаалдгаараа

онцлогтой.

Тус компанийн Vision One платформ нь байгууллагын дотоод мэдээллийн төв болон үүлэн орчныг хамарсан аюулгүй байдлын нэгдсэн хяналт, хамгаалалтыг хэрэгжүүлэх боломж олгодог.

Мөн түүний виртуал хамгаалалтын технологи нь системийг зогсоох, дахин асаах шаардлагагүйгээр аюулгүй байдлын сул талтай хуучин серверүүд болон төвлөрсөн тооцооллын системүүдийг кибер халдлагаас хамгаалдаг. Энэ үйл ажиллагаа нь тасалдах боломжгүй банкны үндсэн системүүдийн хувьд онцгой ач холбогдолтой шийдэл юм.

9. Okta



Үүсгэн байгуулагдсан он: 2009

Төв байр: Калифорни, АНУ

Гүйцэтгэх захирал: Todd McKinnon


Нээлттэй банкны үйлчилгээ болон финтек платформуудын нэгдэл улам өргөжин тэлэхийн хэрээр хэрэглэгчийн таних (KYC) мэдээллийг хамгаалах асуудал банк, даатгалын байгууллагуудын тэргүүлэх зорилтын нэг болоод байна.

Okta нь нээлттэй банкны үйлчилгээний хүрээнд мэдээлэл солилцох дижитал сувгуудыг хамгаалж, харилцагчийн мэдээлэлд хандаж буй гуравдагч талын системүүдийг найдвартай баталгаажуулах замаар мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Сүүлийн жилүүдэд тус компани таних мэдээлэлтэй холбоотой эрсдэлийг илрүүлж, шуурхай хариу арга хэмжээ авах шийдлүүдийг хөгжүүлэхэд түлхүү анхаарч байна.

Workforce Identity Cloud платформ нь санхүүгийн портал, SWIFT сүлжээ болон арилжааны платформ зэрэг чухал системүүдийн нэвтрэх эрхийн аюулгүй байдлыг хангадаг. Нэвтрэх мэдээлэл алдагдахаас сэргийлснээр Okta нь санхүүгийн байгууллагуудад аюулгүй байдлын өндөр түвшний хамгаалалт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

Мөн тус компанийн хиймэл оюун ухаанд суурилсан таних хамгаалалтын технологи нь шинэ харилцагчийг бүртгэх явцад хуурамч дүрс, дуу хоолой ашиглан баталгаажуулалтын системийг мэхлэх оролдлогыг илрүүлж, таслан зогсоодог.



8. Splunk

Үүсгэн байгуулагдсан он: 2003

Төв байр: Калифорни, АНУ

Гүйцэтгэх захирал: Chuck Robbins (Cisco компанийн гүйцэтгэх захирал)

Cisco компани Splunk-ийг худалдан авснаар тус платформ Cisco Talos-ийн кибер аюулын мэдээлэл, шинжилгээний системтэй уялдаатай ажиллах боломжтой болсон.

Үүний үр дүнд санхүүгийн байгууллагуудын аюулгүй байдлын хяналтын төвүүд сүлжээний үйл ажиллагаа болон аюулгүй байдлын мэдээллийг нэгдсэн байдлаар хянах боломжтой болжээ.

Банкууд Splunk-ийн хиймэл оюун ухаанд суурилсан шийдлийг ашиглан эрсдэл багатай залилангийн сэрэмжлүүлгийг автоматаар шалгаж, аюулгүй байдлын багийн ажлын ачааллыг бууруулдаг.

Мөн тус платформ нь системийн үйл ажиллагааны их хэмжээний бүртгэл мэдээллийг боловсруулж, PCI-DSS, SOX болон Basel III зэрэг зохицуулалт, стандартын шаардлагыг хангахад дэмжлэг үзүүлдэг.

Банкны системүүдийн мэдээллийг цогцоор нь харах боломж нь Splunk-ийг аюулгүй байдлын шинжээчид болон зохицуулалтын мэргэжилтнүүдийн гол хэрэгслүүдийн нэг болгожээ.

7. Check Point Software



Үүсгэн байгуулагдсан он: 1993

Төв байр: Калифорни, АНУ

Гүйцэтгэх захирал: Nadav Zafrir

Эрсдэлийг бууруулж, системийн найдвартай ажиллагааг хангахад чиглэсэн хиймэл оюун ухаанд суурилсан кибер аюулгүй байдлын шийдлээрээ Check Point Software санхүүгийн салбарт танигдсан компани юм.

Тус компанийн **Infinity** архитектур нь халдлагыг илрүүлсний дараа хариу арга хэмжээ авах бус, харин халдлага амжилттай хэрэгжихээс өмнө таслан зогсоход чиглэдэг онцлогтой.

Мөн 2026 онд нэвтрүүлэхээр хөгжүүлж буй **Quantum-Safe VPN** шийдлийг ирээдүйд квант тооцооллын хүчин чадлыг ашиглан шифрлэлтийг тайлах эрсдэлээс хамгаалах зорилгоор зарим байгууллагууд туршиж эхлээд байна.

Төв банкууд болон төлбөр тооцооны байгууллагуудын хувьд системийн саатал нь зах зээлийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөх эрсдэлтэй байдаг. Иймээс Check Point-ийн тогтвортой ажиллагаа, найдвартай программ хангамжийн чанар нь тус компанийн шийдлийг сонгох гол хүчин зүйлсийн нэг хэвээр байна.

6. Proofpoint

Үүсгэн байгуулагдсан он: 2002



Төв байр: Калифорни, АНУ

Гүйцэтгэх захирал: Sumit Dhawan


Proofpoint нь ихэнх нарийн зохион байгуулалттай кибер халдлагын эхлэл болдог фишинг халдлагаас байгууллагуудыг хамгаалах чиглэлээр мэргэшсэн компани юм.

Тус компани нь халдагчид удирдах албан тушаалтны дүр эсгэн санхүүгийн гүйлгээ, мөнгөн шилжүүлгийг зөвшөөрүүлэхийг оролддог бизнес имэйл залилан (BEC) төрлийн халдлагаас хамгаалах шийдлээрээ онцлог.

Мөн Proofpoint нь байгууллагын дотоод эрсдэл болон мэдээллийг зөвшөөрөлгүйгээр гадагш дамжуулах сэжигтэй үйлдлүүдийг хянаж, хөрөнгийн удирдлагын компаниудад харилцагчдын нууц мэдээллийг хамгаалахад тусалдаг.

2026 оноос хиймэл оюун ухаанд суурилсан мэдээллийн удирдлагын шийдлүүдийг хөгжүүлж, Microsoft Teams болон Zoom орчинд дамжих хувь хүний нууц мэдээллийг бодит цаг хугацаанд илрүүлж, хамгаалах боломжийг байгууллагуудад олгож байна.

5. Fortinet



Үүсгэн байгуулагдсан он: 2000

Төв байр: Калифорни, АНУ

Гүйцэтгэх захирал: Ken Xie

Fortinet нь банкны салбар нэгжүүд болон даатгалын байгууллагуудын аюулгүй байдлыг хангах чиглэлээр тэргүүлэгч үйлчилгээ үзүүлэгчдийн нэг юм.

Тус компанийн FortiGate платформ нь галт ханын (firewall) хамгаалалт болон сүлжээний аюулгүй холболтын технологийг нэгтгэснээр банк, санхүүгийн байгууллагуудад АТМ төхөөрөмжүүд болон алслагдсан салбаруудаа нэг цогц шийдлээр хамгаалах боломж олгодог.

Fortinet нь өргөн хүрээний орчинд өгөгдөл шифрлэх, кибер аюулаас хамгаалах үйлчилгээг үр ашигтайгаар хүргэхийн зэрэгцээ бусад ижил төрлийн шийдлүүдтэй харьцуулахад нэвтрүүлэлтийн зардлыг бууруулдагаараа давуу талтай.

Түүнчлэн тус компани үйл ажиллагааны технологийн аюулгүй байдлын чиглэлд үйл ажиллагаагаа өргөжүүлж, барилгын удирдлагын систем, хамгаалалтын сейф зэрэг банкны биет дэд бүтцийг хамгаалах шийдлүүдийг хөгжүүлсээр байна.

4. Zscaler



Үүсгэн байгуулагдсан он: 2007

Төв байр: Калифорни, АНУ

Гүйцэтгэх захирал: Jay Chaudhry

Zscaler нь уламжлалт VPN шийдлээс татгалзаж, илүү орчин үеийн хамгаалалтын тогтолцоонд шилжиж буй санхүүгийн байгууллагуудад өргөн хүрээний дэмжлэг үзүүлдэг.

Тус компанийн Zero Trust Exchange платформ нь хэрэглэгчдийг байгууллагын дотоод сүлжээнд шууд холбохгүйгээр шаардлагатай систем, програмд аюулгүйгээр нэвтрэх боломж олгодог. Ингэснээр кибер халдлагад өртөх эрсдэлийг бууруулахаас гадна мэдээллийн хамгаалалт, хадгалалтын зохицуулалтын шаардлагыг хангахад тусалдаг.

Мөн SPLXAI компанийг нэгтгэсний дараа Zscaler нь хиймэл оюун ухааны системүүдийн аюулгүй байдлыг шалгах шинэ боломжуудыг нэвтрүүлжээ. Үүний хүрээнд банкууд өөрсдийн ашиглаж буй үүсгүүр хиймэл оюун ухааны системүүдийг мэдээлэл алдагдах эрсдэл болон аюулгүй байдлын сул талаас нь турших боломжтой болсон байна.

Алсаас ажилладаг банкны ажилтнууд болон санхүүгийн зөвлөхүүдийн хувьд тус платформ нь үүлэн технологид суурилсан нэвтрэх эрхийн удирдлагыг санал болгож, интернэт орчноос үүдэлтэй кибер аюулаас хамгаалдаг.

3. Symantec



Үүсгэн байгуулагдсан он: 1982

Төв байр: Калифорни, АНУ

Гүйцэтгэх захирал: Нок Тан (Broadcom компанийн гүйцэтгэх захирал)


Symantec нь дэлхийн томоохон банкуудын мэдээлэл алдагдахаас хамгаалах шийдлийн тэргүүлэгч нийлүүлэгчдийн нэг хэвээр байна.

Санхүүгийн байгууллагууд тус платформыг ашиглан зээлийн картын мэдээлэл, харилцагчийн хувийн мэдээлэл зэрэг эмзэг өгөгдлийг ангилан тодорхойлж, байгууллагын сүлжээнээс зөвшөөрөлгүйгээр гадагш дамжихаас сэргийлдэг.

Symantec-ийн бодлого, хяналтын систем нь SWIFT төлбөр тооцооны сүлжээ болон бусад банкны үндсэн дэд бүтэцтэй нягт уялдан ажиллаж, зохицуулалтын шаардлагыг хангахад дэмжлэг үзүүлдэг.

Өндөр зохицуулалттай санхүүгийн орчинд Symantec нь мэдээллийн алдагдлаас хамгаалах нарийн түвшний хяналт, хамгаалалтыг хангадаг.

2. CrowdStrike



Үүсгэн байгуулагдсан он: 2011

Эх сурвалж: <https://fintechmagazine.com/top10/top-10-cybersecurity-companies-for-financial-services>

Төв байр: Техас, АНУ

Гүйцэтгэх захирал: George Kurtz

CrowdStrike-ийн гол чиглэлүүдийн нэг нь банкны салбар дахь ransomware халдлага болон төхөөрөмжийн аюулгүй байдлаас хамгаалах шийдэл юм.

Тус компанийн Falcon платформ нь АТМ төхөөрөмж, зөөврийн компьютер болон санхүүгийн системүүдэд ажиллаж, төхөөрөмжүүдийн үйл ажиллагааг тасралтгүй хянаснаар болзошгүй аюул заналыг шуурхай илрүүлэх боломж олгодог.

Falcon Flex загвар нь байгууллагуудад үүлэн орчны хамгаалалт, шинэ үеийн вирусийн эсрэг үйлчилгээ зэрэг аюулгүй байдлын төрөл бүрийн шийдлүүдийг хэрэгцээндээ тохируулан ашиглах уян хатан боломжийг бүрдүүлдэг.

2026 онд CrowdStrike-ийн Charlotte AI хэрэгсэл нь санхүүгийн байгууллагууд болон төлбөрийн чадварын системүүдийг онилсон улс орны дэмжлэгтэй кибер халдлагыг илрүүлж, шинжлэхэд аюулгүй байдлын шинжээчдийн ашигладаг гол хэрэгслүүдийн нэг болж байна.

1. Palo Alto Networks



Үүсгэн байгуулагдсан он: 2005

Төв байр: Техас, АНУ

Гүйцэтгэх захирал: Nikesh Arora

Palo Alto Networks нь дэвшилтэт сүлжээний болон үүлэн орчны хамгаалалт шаарддаг дэлхийн томоохон санхүүгийн байгууллагуудын дунд тэргүүлэх байр сууриа хадгалсаар байна.

2025 оны сүүлээр CyberArk компанийг нэгтгэснээр тус компани өндөр түвшний хандалтын эрхийн удирдлага банкны дэд бүтцийн хамгаалалтын чиглэл дэх боломжоо улам өргөжүүлсэн.

Түүний Cortex XSIAM платформ нь уламжлалт аюулгүй байдлын мэдээлэл, хяналтын системүүдийг орлох шинэ жишиг болж, халдвар авсан системийг 10 секунд хүрэхгүй хугацаанд илрүүлэн тусгаарлах боломжийг байгууллагуудад олгож байна.

Cortex болон Strata платформууд нь өндөр хурдтай санхүүгийн арилжааны шифрлэгдсэн өгөгдлийг шалгахдаа системийн хурд, гүйцэтгэлд хамгийн бага нөлөө үзүүлдгээрээ онцлогтой.

Хиймэл оюун ухаанд суурилсан автоматжуулалтын ачаар Palo Alto Networks нь аюулгүй байдлын багийн гар ажиллагааг бууруулж, байгууллагын дотоод болон үүлэн орчны хамгаалалтыг сайжруулдаг.

СУДЛААЧИЙН ИНДЭР

УЛС ОРНУУДЫН ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ДЭЭВЭР БАЙГУУЛЛАГЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлнэ.

Гүйцэтгэсэн:

СЗХ, Зах зээлийн судалгаа хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн,
Б.Даваамаа davaamaa@frc.mn

ХУРААНГУЙ

Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ) нь бага, дунд орлоготой иргэд болон санхүүгийн үйлчилгээний гадна орхигдсон бүлгийн хэрэгцээг хангах, орлого, хуримтлал, нийгмийн хамгааллын хүртээмжийг өргөжүүлэхэд чухал үүрэгтэй санхүүгийн байгууллага билээ. Тус байгууллагын цаашлаад салбарын тогтвортой хөгжилд ХЗХ-дын ашиг сонирхлыг төлөөлөх, гишүүн ХЗХ-д дэмжлэг үзүүлэх, салбарын зохицуулалтад нөлөөлөх чиг үүрэг бүхий дээвэр байгууллагуудын үйл ажиллагаа нь чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр байгууллагууд нь зөвхөн төлөөлөл, зохицуулалт бус, гишүүн ХЗХ-дын чадавхыг бэхжүүлэх, санхүүжилт, бодлогын дэмжлэг үзүүлэх, олон улсын харилцааг өргөжүүлэх, технологийн шилжилт, дижитал санхүүжилтийг дэмжих зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг. Иймд энэхүү судалгааны ажлаар Дэлхийн ХЗХ-ны зөвлөл (WOCCEU), Азийн ХЗХ-ны холбоо (ACCU), Карибын бүсийн ХЗХ-дын холбоо (CCCU), мөн АНУ-ын CUNA, Өмнөд Солонгосын NACUFOK, Непалын NEFSCUN, Монголын ХЗХ-ны холбоо зэрэг улс, бүс нутгийн голлох байгууллагуудын бүтэц, чиг үүрэг, гишүүнчлэлийн зохион байгуулалт, санхүүжилтийн эх үүсвэр, үйл ажиллагааны механизмыг харьцуулан судаллаа.

УДИРТГАЛ

Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ) нь гишүүнчлэлд суурилсан, хамтын удирдлагатай, ашгийн бус санхүүгийн байгууллага бөгөөд орон нутгийн түвшинд иргэдийн санхүүгийн оролцоог нэмэгдүүлэх, хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээ үзүүлэх замаар нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг онцлогтой. Ялангуяа бага, дунд орлоготой иргэд болон санхүүгийн үйлчилгээний гадна орхигдсон бүлгийн хэрэгцээг хангах, орлого, хуримтлал, нийгмийн хамгааллын хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн.

Дэлхийн улс орнуудад ХЗХ-дын тогтолцоо нь тодорхой төвлөрсөн бүтэцтэй, шат дараалсан зохион байгуулалттайгаар хөгжиж ирсэн бөгөөд энэ хүрээнд ХЗХ-дын ашиг сонирхлыг төлөөлөх, тэдгээрт дэмжлэг үзүүлэх, салбарын зохицуулалтад нөлөөлөх чиг үүрэг бүхий дээвэр байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр байгууллагууд нь зөвхөн төлөөлөл, зохицуулалт бус, мөн гишүүн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, санхүүжилт, бодлогын дэмжлэг үзүүлэх, олон улсын харилцааг өргөжүүлэх, технологийн шилжилт, дижитал санхүүжилтийг дэмжих зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг. Тэд ХЗХ-дын бүс нутгийн болон олон улсын холбоод нь зөвхөн салбарын дуу хоолой болоод зогсохгүй, ХЗХ-дын тогтвортой хөгжил, шинэчлэлийн бодлогыг тодорхойлогч гол субъект болж байна.

Уг судалгааны ажлын зорилго нь олон улсын болон бүс нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг ХЗХ-ны дээвэр байгууллагуудын бүтэц, чиг үүрэг, гишүүнчлэлийн зохион байгуулалт, санхүүжилтийн эх үүсвэр, үйл ажиллагааны механизмыг харьцуулан судлахад оршино. Судалгаанд Дэлхийн ХЗХ-ны зөвлөл (WOCCEU), Азийн ХЗХ-ны холбоо (ACCU), Карибын бүсийн ХЗХ-дын холбоо (CCCU), мөн АНУ-ын CUNA, Өмнөд Солонгосын NACUFOK, Непалын NEFSCUN, Монголын ХЗХ-ны холбоо зэрэг улс, бүс нутгийн голлох байгууллагуудын жишээг хамруулсан. Судалгааны үр дүнд дээрх холбоодын харьцуулсан бүтэц,

санхүүжилтийн загвар, гишүүнчлэлийн хэлбэр, үйлчилгээний цар хүрээ, бодлогын оролцоог тодорхойлж, Монгол Улсад ХЗХ–ны институтын орчныг бэхжүүлэх, салбарын зохицуулалт, төлөөллийн институтын чадавхыг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлэх боломжит олон улсын сайн туршлагыг санал болгоно.

Уг судалгааны ажил нийт 4 бүлэгтэй. Судалгааны хоёр болон гуравдугаар бүлэгт харгалзан бүс нутгийн болон олон улсын ХЗХ–дын дээвэр байгууллагын бүтэц үйл ажиллагаа болон улс орнуудын ХЗХ–дын үндэсний холбоодын бүтэц, чиг үүргийн талаар танилцуулна. Харин эцсийн дөрөвдүгээр бүлэгт дүгнэлт, саналыг оруулав.

ОЛОН УЛСЫН БОЛОН БҮС НУТГИЙН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ДЭЭВЭР БАЙГУУЛЛАГА

Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын зөвлөл (World Council of Credit Unions)

Дэлхийн Хадгаламж, Зээлийн Хоршоодын Зөвлөл (WOCCU) нь 1971 онд байгуулагдсан бөгөөд өнөөгийн байдлаар дэлхийн 118 гаруй орны 87,000 орчим ХЗХ–г нэгтгэн, нийт 375 сая гаруй гишүүнийг төлөөлж буй олон улсын мэргэжлийн байгууллага юм. Тус зөвлөл нь ХЗХ–дын эрх ашгийг олон улсын түвшинд хамгаалах, тэдний тогтвортой өсөлт, хөгжлийг дэмжих, чадавх бэхжүүлэх, боловсрол олгох, хамтын ажиллагааны сүлжээг өргөжүүлэх замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг зорьдог.

Бүтэц зохион байгуулалт: Удирдах байгууллага нь Бүх гишүүдийн хурал бөгөөд гишүүн байгууллагуудын албан ёсны төлөөлөгчдөөс бүрдэнэ. WOCCU–ийн Удирдах зөвлөл нь гишүүн орнуудын төлөөлөгчдийн дундаас сонгогдсон 9–15 саналын эрх бүхий гишүүнээс бүрдэнэ. Зөвлөлийн гишүүд хоёр жилийн хугацаатай томилогддог бөгөөд бүтэц нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, санхүүгийн албаны дарга, засаглал ба сонгуулийн хорооны даргын бүрэлдэхүүнтэй. Удирдах зөвлөл нь жил бүр зохион байгуулагддаг Дэлхийн Хадгаламж, Зээлийн Хоршооны Бага хурлын үеэр болон жилийн туршид тогтмол хуралддаг.

Үндсэн чиг үүрэг: WOCCU нь гишүүдийнхээ өмнөөс дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг:

Олон улсын стандарт тогтоогч байгууллагын өмнө зээлийн хоршоодыг төлөөлөн, мөнгө угаахтай тэмцэх, зохистой харьцаа, татвар, нягтлан бодох бүртгэлийн стандарт зэрэг зохицуулалтын ачааллыг бууруулах, өсөлтийг дэмжих бодлогын нөлөөлөл үзүүлэх;

Танхим болон цахим орчинд хамтын ажиллагаа бий болох нөхцөлийг бүрдүүлж, дэлхийн ХЗХ–дыг хооронд нь холбох;

ХЗХ–ны мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх, тэр дундаа залуу үе болон эмэгтэйчүүдийг чадавхжуулах

сургалт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

Санхүүгийн үйлчилгээ авах боломжгүй бүлгүүдэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж, залуу гишүүдийг татах, жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог дэмжих;

ХЗХ–дод тулгарч буй нийтлэг сорилтуудыг шийдвэрлэх зорилгоор цахим платформ болон хамтарсан технологийн шийдлүүдийг нэвтрүүлэх;

Уур амьсгалд тэсвэртэй, тогтвортой нийгмийг бий болгоход чиглэсэн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох чиглэлд дэмжлэг үзүүлэх.

Гишүүнчлэлийн бүтэц: WOCCU нь гишүүнчлэлээ шууд (Direct) болон хамтрагч (Associate) гэсэн хоёр үндсэн ангилалд хуваадаг.

Шууд гишүүн нь тухайн улс болон бүс нутгийн ХЗХ–дын холбоод шууд гишүүнээр элсэх эрхтэй ба ХЗХ–дын гишүүнчлэлтэй, санхүүгийн хувьд тогтвортой байх шаардлагыг хангасан байна. Гишүүнчлэлийн хураамж нь холбооны гишүүдийн нийт хөрөнгийн хэмжээнд үндэслэн тооцогддог бөгөөд шинэ гишүүнчлэлийн асуудлыг Удирдах зөвлөл хэлэлцэн олонхын саналаар шийдвэрлэнэ.

Хамтрагч гишүүн нь дэмжигч байгууллага, бодлого боловсруулагч агентлаг, олон улсын байгууллага зэрэг байгууллагууд байх бөгөөд санал өгөх эрхгүй ч WOCCU–ийн сүлжээнд нэгдэж, хамтын ажиллагаанд оролцох, мэдээлэл, сургалт, арга хэмжээнд хамрагдах боломжтой. Хамтрагч гишүүд нь жил бүрийн Бүх гишүүдийн хуралд оролцох эрхтэй боловч санал өгөх эрхгүй, мөн удирдах зөвлөлд сонгогдох боломжгүй. 2023 онд WOCCU гишүүнчлэлийн бүтцэдээ шинэчлэл хийж, нэг улсад хэд хэдэн үндэсний холбоодыг туслах гишүүнээр элсүүлэх боломжтой болсон.

Цаашлаад WOCCU нь гишүүнчлэлийн хураамж, олон улсын

донор байгууллагуудын буцалтгүй тусламж, Worldwide Foundation for Credit Unions (WFCU)-ийн хандив, сургалт, арга хэмжээ, зөвлөх үйлчилгээний орлого гэсэн үндсэн 4 эх үүсвэрээс санхүүждэг.

ХЗХ-дод үзүүлэх санхүүгийн дэмжлэг: WOCCU нь гишүүн байгууллагуудаа чадавхжуулах, тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор дараах үндсэн гурван чиглэлд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.

Хөгжлийн төслүүд ба буцалтгүй тусламж: WOCCU нь олон улсын донор байгууллагуудтай стратегийн түншлэл байгуулж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн санхүүжилтийг сайжруулах, эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдлийг бэхжүүлэх, дижитал санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр төслүүдийг хэрэгжүүлдэг. Тухайлбал, 2024 онд тус байгууллага Баруун Африкийн ХЗХ-ны сүлжээнд уур амьсгалын санхүүжилтийн туршилтын төсөл хэрэгжүүлэх зорилгоор 1.8 сая ам.долларын буцалтгүй тусламж олгосон. Энэхүү төсөл нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг даван туулах чадвартай санхүүгийн үйлчилгээ боловсруулах, орон нутгийн иргэдийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд чиглэгдсэн (WOCCU, 2024).

Гамшгийн тусламж, дэмжлэг: WOCCU-ийн дэргэдэх WFCU нь байгалийн гамшиг, улс төрийн хямрал, эдийн засгийн огцом өөрчлөлт зэрэг онцгой нөхцөл байдалд өртсөн гишүүн байгууллагуудад шуурхай тусламж үзүүлдэг. Тухайлбал, 2025 онд Украин Улсын ХЗХ-дын тогтвортой үйл ажиллагааг дэмжих зорилгоор 210,000 ам.долларын буцалтгүй санхүүжилт олгосон. Энэхүү тусламж нь жижиг, дунд бизнесүүдэд зориулсан зээл олголтыг үргэлжлүүлэх, хөдөө аж ахуйн улирлын санхүүжилтийг тасралтгүй хүргэхэд чиглэсэн (WOCCU, 2025).

Техникийн туслалцаа ба чадавх бэхжүүлэх хөтөлбөр: WOCCU нь хадгаламж, зээлийн хоршоодын институтийн чадавхыг бэхжүүлэх, гишүүдэд үзүүлэх үйлчилгээний үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор техникийн туслалцаа үзүүлдэг. Үүнд дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлага, шинэ бүтээгдэхүүн, дижитал шийдэл нэвтрүүлэх зэрэг багтдаг. Эдгээр хөтөлбөрүүд нь зөвхөн тухайн байгууллагын түвшинд бус, бүс нутгийн санхүүгийн тогтолцооны тогтвортой байдалд нөлөөлөхүйц өргөн хүрээг хамардаг (WOCCU, 2024).

Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (Association of Asian confederation of credit unions)

Азийн Хадгаламж, Зээлийн Хоршоодын Холбоо (ACCU)-г 1971 онд Сөүл хотод Өмнөд Солонгос, Япон, Хонконг, БНСУ, Малайз, Филиппин, Индонез, Тайвань, Тайланд болон Өмнөд Вьетнам зэрэг улсын ХЗХ-дын төлөөлөгчид үүсгэн байгуулсан бөгөөд Ази тивийн 22 орны 33,200 орчим ХЗХ-г нэгтгэн, нийт 48.8 сая гаруй гишүүний эрх ашгийг төлөөлөн ажилладаг бүс нутгийн хэмжээний байгууллага юм.

Бүтэц, зохион байгуулалт: ACCU-н дээд удирдах байгууллага нь Бүх гишүүдийн хурал бөгөөд гишүүн байгууллагуудын албан ёсны төлөөлөгчдөөс бүрдэнэ. Харин Удирдах зөвлөл нь Бүх гишүүдийн хурлаас сонгогдсон 5 гишүүнээс бүрдэх ба үүнд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, нарийн бичгийн дарга, санхүүч багтана. Гүйцэтгэх захирал нь саналын эрхгүйгээр Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд ордог бөгөөд нэг гишүүн 3-аас дээш удаа дараалан сонгогдох боломжгүй.

Үндсэн чиг үүрэг: ACCU нь бүс нутгийн хадгаламж, зээлийн хоршоодын институтийн чадавхыг бэхжүүлэх, санхүүгийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг:

ХЗХ-дын удирдлага, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, тэр дундаа залуу үе болон эмэгтэйчүүдийн манлайлыг дэмжих зорилготой сургалт, хөгжлийн боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;

ХЗХ-ны зохицуулах эрх зүйн орчин, хяналт шалгалтын тогтолцоонд нөлөөлөх зорилгоор үндэсний болон бүс нутгийн түвшинд бодлогын зөвлөмж боловсруулж, олон улсын стандарт тогтоогч байгууллагуудтай хамтран ажиллах;

Танхим болон цахим хурал, уулзалт, чуулган, форум, менежментийн туршлага солилцох хөтөлбөрүүдийг зохион байгуулж, бүс нутгийн ХЗХ-д хооронд харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх;

Хөдөө орон нутаг, эмзэг бүлгийн хүн ам, залуучууд, эмэгтэйчүүд зэрэг санхүүгийн үйлчилгээний гадуурх бүлгүүд рүү чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй санхүүгийн бүтээгдэхүүн, байгальд ээлтэй зээл, ногоон хөрөнгө оруулалтын шийдлүүдийг хөгжүүлэхэд гишүүддээ бодлого, сургалт, төсөл хэлбэрээр дэмжлэг үзүүлэх;

ХЗХ-д тулгамддаг нийтлэг сорилтуудыг шийдвэрлэх зорилгоор цахим платформ, дижитал шийдлийг хамтран хөгжүүлж, гишүүн байгууллагууддаа зөвлөх үйлчилгээ үзүүлэх.

Гишүүнчлэлийн бүтэц: ACCU нь гишүүнчлэлээ энгийн гишүүн (Ordinary Member), туслах гишүүн (Affiliate Member), хамтрагч гишүүн (Associate Member), дэмжигч гишүүн (Supportive Member) хэмээн 4 ангилдаг.

Энгийн гишүүнчлэл нь тухайн улсын ХЗХ-ны үндэсний холбоонд зориулагдсан бөгөөд ACCU-ийн саналын эрхтэй гишүүнчлэл юм. Энгийн гишүүнээр элсэхэд хамгийн багадаа 20,000 гишүүнтэй, эсхүл тухайн улсын нийт хүн амын 1 хувьтай тэнцэхүйц гишүүнтэй байх шаардлагатай ба гишүүнчлэлийн жилийн хураамж нь тухайн байгууллагын нийт хөрөнгийн хэмжээнээс хамааран 2,000–5,000 ам.долларын хооронд байдаг.

Туслах гишүүн нь ХЗХ-дын холбоо нь энгийн гишүүнчлэлийн шалгуурыг хараахан хангаагүй тохиолдолд туслах гишүүнээр элсэх боломжтой. Энэ ангиллын гишүүд саналын эрхгүй боловч ACCU-ийн үйл ажиллагаанд оролцох боломжтой бөгөөд жил бүр 1,500 ам.долларын гишүүнчлэлийн хураамж төлдөг.

Харин хамтрагч гишүүнд Санхүүгийн хоршоо, боловсрол, судалгааны байгууллагууд, дэмжигч, ACCU-ийн ивээн тэтгэгч байгууллагууд багтана. Энэ төрлийн гишүүд саналын эрхгүй бөгөөд жил бүрийн хураамж 1,000 ам.доллар байдаг бол дэмжигч гишүүн нь ХЗХ-ны нэгж байгууллагууд, хоршооллын банкнууд, болон ХЗХ-ны хөгжилд дэмжлэг үзүүлдэг аливаа байгууллагуудад нээлттэй. Дэмжигч гишүүн нь ACCU-ийн үйл ажиллагаанд хязгаарлагдмал оролцоотой, саналын эрхгүй боловч мэдээлэл солилцоо, сургалт, сүлжээний харилцаанд хамрагдах боломжийг олгодог. Жилийн гишүүнчлэлийн хураамж нь 500 ам.доллар байна.

Түүнчлэн, ACCU-ийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр нь гишүүнчлэлийн хураамж, төслийн санхүүжилт ба буцалтгүй тусламж, сургалт, арга хэмжээний орлого, хамтрагч гишүүн, дэмжигч байгууллагуудын хандив, санхүүгийн дэмжлэгээс бүрддэг.

ХЗХ-дод үзүүлэх санхүүгийн дэмжлэг: ACCU нь гишүүн байгууллагуудаа чадавхжуулах, тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор дараах үндсэн 4 чиглэлд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.

Буцалтгүй тусламж болон төслийн санхүүжилт: ACCU олон улсын донор байгууллагуудтай стратегийн түншлэл тогтоож, бүс нутгийн ХЗХ-дын хэрэгцээнд нийцүүлсэн буцалтгүй тусламж болон хөгжлийн төслийг амжилттай хэрэгжүүлдэг. Тухайлбал, 2023–2024 онд ACCU нь Канадын Хөгжлийн

Гадаад Харилцааны Газартай (Global Affairs Canada) хамтран “Enhancing the Role of Credit Unions in Sustainable Agricultural Finance” төслийг Тайланд, Индонез, Филиппин улсад хэрэгжүүлсэн. Энэхүү жижиг фермерүүдэд чиглэсэн хөдөө аж ахуйн зээл, байгальд ээлтэй бүтээгдэхүүн, зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн төсөлд нийт 1.2 сая ам.долларын буцалтгүй санхүүжилт олгогджээ (ACCU, 2024, p.12).

Хандив, тусламж: ACCU нь гамшгийн нөхцөл байдал үүссэн үед гишүүн холбоодоор дамжуулан шуурхай санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Жишээлбэл, 2023 онд Турк Улсад болсон газар хөдлөлтийн дараа ACCU болон WFCU-ийн хамтын ажиллагааны хүрээнд Туркийн Зээлийн Хоршоодын Холбоонд 75,000 ам.долларын тусламжийг шуурхай хэлбэрээр олгож, ХЗХ-дын нурсан барилга, байгууламжийг сэргээн босгох, түр байршилд үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд зарцуулсан (WFCU, 2024, p.9).

Техникийн туслалцаа болон чадавх бэхжүүлэх: ХЗХ-дын үйл ажиллагааны үр ашиг, тогтвортой байдлыг сайжруулах зорилгоор олон улсын зөвлөх багийн оролцоотойгоор техникийн туслалцаа үзүүлдэг. Үүнд: дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, гишүүн төвтэй санхүүгийн бүтээгдэхүүн, мэдээллийн системийн шинэчлэл зэрэг чиглэл багтдаг.

Сургалт, тэтгэлэг: Гишүүн байгууллагуудынхаа ажилтнууд, удирдах албан тушаалтнуудад зориулан ACCU Development Education (ACCUDE), Young Leadership Academy зэрэг бүс нутгийн сургалт, чадавхжуулах хөтөлбөрүүдийг зохион байгуулдаг. Жишээлбэл, 2023 онд зохион байгуулсан “Women in Leadership for Financial Cooperatives” сургалтад 10 орны 60 гаруй эмэгтэй удирдагчийн 70 гаруй хувь нь дараагийн зургаан сарын хугацаанд байгууллагадаа шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлсэн үр дүн гарсан (ACCU, 2024, p.20).

УЛС ОРНУУДЫН ХЗХ–ДЫН ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГА

АНУ–ын Хадгаламж, зээлийн Хоршоодын Үндэсний холбоо) America's Credit Unions)

Америкийн ХЗХ–дын Үндэсний Холбоо (Credit Union National Association, CUNA) нь 1934 онд байгуулагдсан бөгөөд 2023 онд ХЗХ–дын даатгалын үндэсний Холбоо (NAFCU)–той нэгдэж, "America's Credit Unions" нэртэйгээр 140 гаруй сая гишүүдийг төлөөлөн үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна. Энэхүү байгууллага нь АНУ–ын бүх төрлийн зээлийн хоршоодыг төлөөлөн, тэдний эрх ашгийг хамгаалах, бодлогын дэмжлэг үзүүлэх, сургалт, судалгаа, зохицуулалтын зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагаа явуулах, хамтын ажиллагаа, туршлага солилцооны сүлжээ бүрдүүлэх, судалгаа, мэдээлэл түгээх, стандартыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

Бүтэц, зохион байгуулалт: Удирдлагын бүтэц нь Гүйцэтгэх захирал, Удирдах зөвлөл болон бодлогын хорооноос бүрдэнэ. Удирдах зөвлөлийг гишүүнийг ХЗХ–дын төлөөллөөс сонгодог бөгөөд бүсчилсэн төлөөллийг хангах үүднээс бүс нутаг бүрээс төлөөлөл оруулдаг. Удирдах зөвлөлийн гишүүд нь санхүүгийн салбарт дор хаяж 5 жилийн туршлагатай, холбогдох шалгуурыг хангасан, гишүүн байгууллагыг бодитоор төлөөлөх чадвартай байх шаардлагатай. Удирдах зөвлөлийн гишүүд нь холбооны стратеги, бодлого, төсөв, хууль эрх зүйн байр суурь, засаглалын зарчмыг тодорхойлох, байгууллагын үйл ажиллагааг хянан батлах үүрэгтэй.

Гүйцэтгэх захирал нь өдөр тутмын удирдлагыг хэрэгжүүлж, Удирдах зөвлөлд тайлагнах үүрэгтэй. Түүнд тавигдах үндсэн шаардлага нь олон нийт, салбарын удирдлага, хууль, бодлого, стратегийн чиглэлд өндөр мэдлэг, ур чадвартай байх бөгөөд санхүүгийн салбар, төрийн бус байгууллага, олон нийтийн зохицуулалт бүхий орчинд удирдах албан тушаал хашиж байсан туршлагатай байх ёстой. Мөн гишүүн байгууллагуудын хэрэгцээг ойлгох, олон улсын хөгжил, инновацийн хандлагыг удирдлагад шингээх ур чадвартай байх шаардлагатай.

Мөн энэхүү холбоо нь хувь хүний гишүүнчлэлтэй мэргэжлийн зөвлөлийг ажиллуулдаг. Энэхүү зөвлөлд ХЗХ–д цалинтай ажиллаж буй мэргэжилтэн, удирдах албан тушаалтан хамрагдах ба энэ нь гишүүнчлэлээс тусдаа, сайн дурын, төлбөртэй байна.

Гишүүнчлэл: Холбооны гишүүнчлэл нь сайн дурын үндсэн

дээр явагддаг бөгөөд холбооны болон мужийн эрхтэй ХЗХ–ыг хамардаг. Гишүүн байгууллагууд нь жил бүр гишүүнчлэлийн хураамж төлөх үүрэгтэй бөгөөд энэхүү хураамж нь тухайн ХЗХ–ны нийт хөрөнгө болон үйл ажиллагааны цар хүрээнд хамааран тодорхойлогддог. Гишүүнчлэлийн төлбөрөөс бүрдсэн орлого нь America's Credit Unions–ийн үйл ажиллагааны гол эх үүсвэр болж, бодлого боловсруулалт, гишүүдийн дэмжлэг, сургалт судалгаанд зарцуулагддаг.

Тус холбоо нь гишүүн байгууллагуудаа албан ёсоор ангилдаггүй боловч гишүүн байгууллагуудын хэмжээ, зохицуулалтын статус (холбооны зохицуулалттай, эсхүл мужийн), үйл ажиллагааны цар хүрээ, мөн Зөвлөлийн гишүүдийн чиглэл зэргийг харгалзан үйлчилгээг ялгаатай байдлаар үзүүлдэг:

\$100 саяас бага хөрөнгөтэй – жижиг ХЗХ;

\$100–500 саяас бага хөрөнгөтэй – дунд ХЗХ;

\$500 саяас их хөрөнгөтэй – том ХЗХ.

Жишээлбэл, жижиг ХЗХ–д зориулсан сургалтын хөтөлбөр, стандартчилсан баримт бичиг, үйл ажиллагааны зөвлөмж бүхий багц, хураамжийн бууруулсан хувь хэмжээ зэрэг хүртээмжтэй үйлчилгээ санал болгодог. Түүнчлэн жижиг, дунд ХЗХ–уудыг төлөөлөх тусгайлсан зөвлөмжийн бүлгүүд ажилладаг (CUNA, 2024).

Харин томоохон ХЗХ–ууд илүү нарийвчилсан бодлогын дэмжлэг, салбарын гүнзгийрүүлсэн судалгаа, хуулийн өөрчлөлтийн талаар зөвлөгөө авах, Конгресст чиглэсэн лобби үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, стратеги төлөвлөлтөд нөлөөлөх боломжтой. Үүнээс гадна, том ХЗХ–дын төлөөлөл бүхий бодлогын хороо, ажлын хэсгүүдийг бүрдүүлж, холбооны үндэсний шийдвэр гаргалтад шууд оролцдог онцлогтой (Filene Research Institute, 2023).

Сургалт, судалгаа: America's Credit Unions нь АНУ–ын ХЗХ–дын мэргэжлийн хөгжлийг дэмжих өргөн хүрээтэй сургалт, судалгааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

- 26 сэдвийн хүрээнд интерактив сургалтын хөтөлбөрүүд.

- төлбөртэй eSchool болон вэбинаруудаар дамжуулан мэргэжлийн сертификат олгох сургалтууд.

Сургалтын явцыг хянах, тайлагнах боломж бүхий сургалтын удирдлагын систем.

Мөн ХЗХ–ны стратеги төлөвлөлтөд шаардлагатай салбарын чиг хандлага, эдийн засгийн таамаглал, шинжилгээг агуулсан E–Scan тайланг жил бүр гаргадаг ба хууль, журам дагаж мөрдөхөд дэмжлэг үзүүлэх гарын авлага, Зохицуулалт ба хууль эрх зүйн өөрчлөлтийн талаарх ном, товхимол бүхий онлайн номын сантай.

Хөрөнгийн эх үүсвэр: Тус байгууллагын санхүүжилтийн үндсэн эх үүсвэр нь дараах бүтэцтэй байна:

Гишүүнчлэлийн хураамж: Энэ нь хамгийн гол санхүүжилтийн эх үүсвэр бөгөөд холбооны болон мужийн эрхтэй ХЗХ–доос жилийн үндсэн дээр хураамж авдаг ба хураамжийн хэмжээг тухайн ХЗХ–ны нийт хөрөнгийн хэмжээ, гишүүдийн тоо, үйл ажиллагааны цар хүрээ зэргээс хамаарч тогтоодог;

Сургалт, зөвлөх үйлчилгээний орлого: Councils, online webinars, CUNA Management School, national conferences зэрэг сургалтын хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн хураамж, сургалтын төлбөр;

Ивээн тэтгэх ба хамтын ажиллагааны санхүүжилт: Корпорацийн түншлэлүүд, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, бизнесийн зөвлөхүүд, технологийн шийдэл нийлүүлэгчдээс спонсоршип хэлбэрээр санхүүжилт татах;

Хандив, тусламж: Credit Union Legislative Action Council (CULAC) зэрэг улс төрийн болон хөгжлийн зорилготой сангуудаар дамжуулан хандив татдаг ба үүнийг төрийн бодлогод нөлөөлөх зорилгоор ашигладаг.

3.2 Өмнөд Солонгос Улсын ХЗХ–дын Үндэсний холбоо (National Credit Union Federation of Korea –NACUFOK)

Үндэсний ХЗХ–дын Холбоо (National Credit Union Federation of Korea – NACUFOK) нь 1964 онд байгуулагдсан, ашгийн төлөө бус, гишүүнчлэлд суурилсан байгууллага бөгөөд БНСУ–ын ХЗХ–дын салбарыг төлөөлөх үүргийг гүйцэтгэдэг. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар тус холбоо нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 869 ХЗХ–н өөртөө нэгтгэсэн.

Байгууллагын бүтэц, зохион байгуулалт нь төв болон орон нутгийн үйл ажиллагаа явуулдаг. Тодруулбал, NACUFOK нь төв байгууллагын хэмжээнд 9 газар, 72 багтай бөгөөд улс орон даяар байрлах 16 орон нутгийн төлөөлөгчийн газар болон хоёр мэргэжлийн сургалтын төвөөр дамжуулан гишүүн байгууллагуудаа чадавхжуулах, бодлогын дэмжлэг үзүүлэх ажлыг хэрэгжүүлдэг.

Бүтэц, зохион байгуулалт: NACUFOK нь нэгдсэн бүтэцтэй,

гишүүнчлэлд суурилсан байгууллага бөгөөд түүний засаглалын дээд байгууллага нь Бүх гишүүдийн хурал юм. Тус хурлыг жил бүрийн хоёрдугаар сард зохион байгуулдаг бөгөөд дараах чухал асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг. Үүнд:

Байгууллагын дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт;

Гишүүнчлэлийн хураамж, түүний хэмжээг тогтоох;

Үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөө батлах;

Удирдах албан тушаалтныг сонгох, томилох, чөлөөлөх;

ХЗХ–дын 1/5–аас доошгүй нь дэмжсэн асуудлыг хэлэлцэх;

Байгууллагын дүрэмд заасан, удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг шийдвэрлэх.

Бүх гишүүдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Төлөөлөн удирдах зөвлөл нь холбооны удирдлагын гол бүрэлдэхүүн юм. Энэхүү зөвлөл нь дарга, гүйцэтгэх захирал болон чиглэл хариуцсан захирлуудаас бүрддэг бөгөөд үүнд:

Зээлийн үйл ажиллагаа хариуцсан захирал;

Харилцан тусламжийн сангийн асуудал хариуцсан захирал;

Удирдлагын зохион байгуулалт хариуцсан захирал багтана.

Мөн NACUFOK–ийн дэргэд Хяналтын хороо ажилладаг. Тус хороо нь холбооны санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгийн байдал, нягтлан бодох бүртгэл, баримт бичиг, дотоод хяналтын тогтолцоонд тогтмол хяналт шалгалт хийдэг. Хяналтын хорооны үүрэгт хамаарах асуудлыг илрүүлсэн тохиолдолд Бүх гишүүдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд тайлан илгээж, зохих арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлдэг. Хяналтын хороо нь нийт 5 гишүүнтэй байх бөгөөд үүний 3 нь хөндлөнгийн шинжээч байх шаардлагатай. Эдгээр шинжээчид нь Солонгос Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон шалгуурыг хангах ёстой.

Гишүүнчлэл: NACUFOK нь улсынхаа бүх ХЗХ–дыг гишүүнээр элсүүлсэн бөгөөд гишүүнчлэл нь заавал байх шинжтэй (mandatory membership) юм. Тус холбооны гишүүнчлэлд ХЗХ–д, харилцан туслалцааны байгууллагууд, салбар холбоод багтана.

Үндсэн чиг үүрэг: NACUFOK дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг:

Гишүүн ХЗХ–дын нягтлан бодох бүртгэл, эрсдэлийн удирдлага, гүйцэтгэлийн тайлагналд хяналт тавих, менежментийн зөвлөгөө өгөх (ХЗХ–ны тухай хуульд заасны

дагуу NACUFOK нь гишүүн ХЗХ-уудыг удирдамжаар хангах, хяналт тавих, зохицуулалтын үүрэг гүйцэтгэх эрхтэй);

Хадгаламж хамгааллын санг байгуулж, удирдах;

ХЗХ-ны зээлийн эрсдэлийн хамгаалалт, хямралын үеийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Харилцан туслалцааны сан”-г байгуулах, ажиллуулах;

Гишүүн байгууллагуудад зориулсан мэргэжлийн сургалт, бодлогын судалгаа явуулж хөгжлийн стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлэх;

Цахим үйлчилгээний платформ, төвлөрсөн тайлангийн систем, нэгдсэн дотоод хяналт, дижитал төлбөр тооцооны шийдлийг нэвтрүүлэх;

Зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх;

Засгийн газар болон Банкны хяналтын байгууллагатай хамтран ХЗХ-дын хууль, журмын шинэчлэлд ХЗХ-ны эрх ашгийг хамгаалах.

Хадгаламж хамгааллын сан: БНСУ-ын “Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль”-ийн 9 дүгээр хэсгийн 71 дүгээр зүйлд заасны дагуу NACUFOK нь Хадгаламж хамгааллын санг байгуулж, удирдах үүрэгтэй. Уг сан нь гишүүдийн аливаа хадгаламж, бусад орлого, харилцан тусламжийн сан, мөн бэлэн мөнгөний чекэнд зориулсан тусгай хадгаламжийг буцаан олгох, гишүүдийн хөрөнгийг хамгаалах, ХЗХ-дын тогтвортой, эрүүл хөгжлийг дэмжих үндсэн зорилготой (Credit Unions Act, Article 71).

Сангийн удирдлагын тогтолцоог хангах зорилгоор тус холбоо нь Нөөцийн удирдлагын хороо (Reserve Management Committee) байгуулдаг бөгөөд тус хорооны бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаа болон сангийн нийт зохион байгуулалт, удирдлагатай холбоотой бусад асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан тусгай журмаар зохицуулдаг (Credit Unions Act, Article 71(3)).

Сангийн хөрөнгө дараах эх үүсвэрүүдээс бүрдэнэ. Үүнд:

ХЗХ-д болон холбооны санд төлөх шимтгэл) Тус шимтгэлийг буцаан олгохыг сангаас шаардахгүй ба шимтгэлийн хувь нь ХЗХ тус бүрд түүний удирдлага, санхүүгийн байдлыг харгалзан өөр өөрөөр тогтоож болно;(

Бусад данснаас шилжүүлсэн мөнгө болон зээлсэн мөнгө;

Сангийн үйл ажиллагаанаас олсон ашиг;

Засгийн газраас зээлсэн мөнгө;

Бусад орлого.

Сангийн хөрөнгийг зөвхөн дараах тохиолдолд ашиглана. Үүнд:

ХЗХ гишүүдийн хадгаламж, хүүгийн орлого зэргийг төлөх үүргийг биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд;

ХЗХ дампуурах эсвэл түр зогсоох тохиолдолд гишүүдийн санхүүгийн хохирлыг багасгах зорилгоор сангаас төлбөр олгох;

Холбоо өөрөө харилцан тусламжийн сан) mutual-aid funds), чек зэрэг тусгай хадгаламжийг буцаан төлөх боломжгүй болсон тохиолдолд;

ХЗХ-дод шаардлагатай санхүүгийн дэмжлэг үзүүлэх буюу зээл олгох (38-р зүйл, 2 дахь хэсэгт заасан);

Сангийн удирдлага, үйл ажиллагаанд холбогдох бусад зардлыг санхүүжүүлэх.

NACUFOK нь гишүүн ХЗХ-дын эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зуучлах үйлчилгээ үзүүлэх, төлөөлөх чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг бол тус байгууллагын үйл ажиллагаанд БНСУ-ын Санхүүгийн Хяналтын Алба (Financial Supervisory Service, FSS)-аас хяналт, шалгалт тогтмол хийж, зохистой засаглал, санхүүгийн сахилга батыг хангахад чиглэсэн хяналтын механизмыг хэрэгжүүлдэг.

Хөрөнгийн эх үүсвэр: Тус байгууллагын санхүүжилт нь олон төрлийн санхүүгийн эх үүсвэрт тулгуурладаг.

Гишүүнчлэлийн хураамж, шимтгэл: гишүүнчлэлийн хураамж, үйлчилгээний шимтгэл, хяналт, шалгалтын төлбөр;

Хөрөнгө оруулалтын орлого: Хадгаламж хамгааллын сан болон Харилцан тусламжийн сангийн хөрөнгийг удирдах;

Санхүүгийн үйлчилгээний хураамж: төвлөрсөн төлбөр тооцооны үйлчилгээ гэх мэт, зээлийн үйл ажиллагааны хүүгийн орлого;

Засгийн газраас авсан зээл, дэмжлэг: ХЗХ-ны тогтолцоог тогтворжуулах, шаардлагатай нөхцөлд Засгийн газраас хөнгөлөлттэй зээл авах.

Сургалт, зөвлөх үйлчилгээ, хэвлэл мэдээллийн орлого: Сургалтын төлбөр, семинарын оролцогчийн хураамж, тайлан хэвлэл, зөвлөх үйлчилгээний орлого, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр санхүүжилт.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Хадгаламж, зээлийн хоршоод (ХЗХ) нь гишүүдийнхээ санхүүгийн хэрэгцээг хангах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн эдийн засгийн оролцоог дэмжихэд чиглэсэн, харилцан туслалцах зарчимд тулгуурласан санхүүгийн хамтын байгууллага юм. Энэхүү ХЗХ-дын тогтвортой, үр ашигтай үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн институтийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор ХЗХ-дын дээд шатны байгууллагыг эрх зүйн зохицуулалт, бодлого, санхүүгийн дэмжлэг бүхий тогтолцооны хүрээнд байгуулж хөгжүүлж иржээ. Энэхүү судалгааны ажлаар АНУ, БНСУ, Непал улсуудын ХЗХ-дын дээвэр байгууллага болон олон улсын түвшний байгууллагууд болох WOCSSU, ACCU, CCCU-ийн бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт, гишүүнчлэл, хөрөнгийн эх үүсвэр, тогтворжилт болон хадгаламж хамгааллын сангийн талаар судалгаа хийж, Монгол Улсад хэрэгжүүлж болох зохистой туршлагыг тодорхойлохыг зорилоо.

Судалгааны үр дүнгээс харахад, дээрх байгууллагууд нь гишүүн ХЗХ-уудыг хууль, бодлогын түвшинд төлөөлөх, санхүүгийн эрсдэлээс хамгаалах нөөц сан бүрдүүлэх, CFFI (төвлөрсөн санхүүжилтийн механизм)-ыг хэрэгжүүлэх, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэлийг стандартчилах, мэргэжлийн сургалт, мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх зэргээр стратегийн болон дэмжлэгийн чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, NEFSCUN нь CFFI, тогтворжилтын сангаар дамжуулан ХЗХ-дын санхүүгийн тогтвортой байдлыг дэмждэг. Харин NACUFOK нь БНСУ-ын хэмжээнд хадгаламж хамгаалах сан, зээлийн батлан даалтын тогтолцоо, төлбөр тооцооны төвлөрсөн үйлчилгээ зэрэг хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Монгол Улсын хувьд МХЗХҮХ нь "Хадгаламж, зээлийн хоршооны тухай" хуулийн дагуу тогтворжилтын үйлчилгээ үзүүлэх эрхтэй боловч "Төрийн бус байгууллагын тухай" хуулиар санхүүгийн буюу бизнесийн үйл ажиллагаа эрхлэх нь хязгаарлагдмал байна. Уг хуулиар төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, ажилтнуудын хувийн ашиг сонирхолд нийцүүлэн байгууллагын хөрөнгөөр үйл ажиллагаа явуулахыг хориглосон нь тогтворжилтын сангийн бодит хэрэгжилтэд эрх зүйн саад үүсгэж байна. Мөн Монгол Улсын ХЗХ-ны дээвэр байгууллагыг бусад улс орнуудтай харьцуулахад одоогоор үйл ажиллагааны идэвхжил нь сул байна.

Иймд олон улсын туршлага, Монгол Улсын нөхцөл байдалд үндэслэн дараах санал, зөвлөмжийг гаргасан болно:

- ◆ МХЗХҮХ-ийн ХЗХ-ний тухай хуулиар олгогдсон санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа нь "Төрийн бус байгууллагын тухай" хуулиар хязгаарлагдаж буй тул "Мэргэжлийн нэгдсэн холбоо"-ны хэлбэрт шилжүүлэн бүртгэх, эсхүл тогтворжилтын сангийн үйл ажиллагааг явуулах харьяа компани, сан байгуулах;
- ◆ МХЗХҮХ-г тогтворжилтын санг хууль, дүрэмд нийцүүлэн байгуулж, ажиллуулахад чиглэсэн сангийн зорилго, бүтэц, хөрөнгийн эх үүсвэр, дотоод хяналт, нээлттэй удирдлагын зохион байгуулалт бүхий тусгай дүрэм боловсруулж батлах;
- ◆ МХЗХҮХ-ийн хүний нөөцийг чадавхжуулж, олон улсын хөгжлийн байгууллага, төсөл хөтөлбөр, дотоод, гадаадын хандивлагч, хөрөнгө оруулагчдыг татах механизмыг боловсронгуй болгох;
- ◆ eSchool болон вэбинаруудаар дамжуулан ХЗХ-дын ажилчдыг чадавхжуулах, мэдлэг солилцох сургалт судалгааг тогтмол зохион байгуулах;
- ◆ Төвлөрсөн санхүүжилтийн механизмыг нэвтрүүлэх талаар судлах;
- ◆ Цахим үйлчилгээний платформ, төвлөрсөн тайлангийн систем, нэгдсэн дотоод хяналт, дижитал төлбөр тооцооны шийдлийг нэвтрүүлэх;
- ◆ Хадгаламж хамгааллын санг байгуулж хууль, дүрэмд нийцүүлэн байгуулж, ажиллуулахад чиглэсэн сангийн зорилго, бүтэц, хөрөнгийн эх үүсвэр, дотоод хяналт, нээлттэй удирдлагын зохион байгуулалт бүхий нарийвчилсан журмаар зохицуулах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ◆ Association of Asian Confederation of Credit Unions (ACCU). (2024). Annual report 2024. https://webadmin.crplk.com/media/Association%20of%20Asian%20Confederation%20of%20Credit%20Unions/Documents/Annual%20Report/ACCU%20Annual%20Reports/2023_to_2024_Annual_Report_1.pdf
- ◆ Association of Asian Confederation of Credit Unions. (n.d.). ACCU. <https://aaccu.coop/>
- ◆ Caribbean Confederation of Credit Unions. (n.d.). CCCU. <https://caribccu.coop/>
- ◆ Korea Legislation Research Institute. (n.d.). Credit Unions Act. Republic of Korea. https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=61479&type=part&key=10
- ◆ Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо. (n.d.). Mongolian Confederation of Credit Unions. <https://www.moccu.mn/>
- ◆ National Credit Union Federation of Korea (NCUFOK). (n.d.). NCUFOK. <https://www.cu.co.kr/english/main.do>
- ◆ Nepal Federation of Savings and Credit Cooperative Unions (NEFSCUN). (n.d.). NEFSCUN. <https://www.nefscun.org.np/>
- ◆ America's Credit Unions. (n.d.). <https://www.americascreditunions.org>
- ◆ World Council of Credit Unions. (n.d.). World Council of Credit Unions. <https://www.woccu.org/>
- ◆ World Council of Credit Unions. (2025, May 5). WOCCU and WFCU sustain vital support for Ukraine's credit unions despite USAID cuts. https://www.woccu.org/newsroom/releases/WOCCU_and_WFCU_Sustain_Vital_Support_for_Ukraines_Credit_Unions_Despite_USAID_Cuts
- ◆ Монгол Улсын хууль. (2011). Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail/8772>

ХУВИЙН САНХҮҮ ДЭХ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ

Технологийн хөгжлийн эрин үед орлого, зарлагаа хянах, хөрөнгө оруулах, санхүүгийн зорилгодоо хүрэх, төлөвлөх, сахилга баттай байх үйл явцыг технологи илүү хялбар, хурдан, ухаалаг болгож байна.



Технологи нь хувийн санхүүг хэрхэн дэмждэг вэ?



Санхүүгийн хяналт

Санхүүгээ хялбар байдлаар хянах боломжийг олгодог.



Төлбөр тооцоо

Төлбөр хурдан тооцоог гүйцэтгэх шуурхай боломжтой.



Ухаалаг зөвлөгөө

Санхүүгийн мэдээлэл хүртээмжтэй болж, өөрийн нөхцөлд тохирсон санхүүгийн шинжилгээ хийлгэх боломжтой.



Автомат хуримтлал

Хуримтлал үүсгэх дадал бий болгож, мөнгөө зөв удирдахад нь тусалдаг.

Технологийг хувийн санхүүдээ ашиглахдаа анхаарах зүйлс



Хувийн мэдээллийг хамгаалах

Нууц үг, картын мэдээлэл, OTP кодыг бусадтай хуваалцахгүй байх.



Эрсдэлээс сэргийлэх

Хуурамч вэбсайт, холбоос зэргээс болгоомжилж, албан ёсны эсэхийг шалгах.



Мэдээллээ тогтмол хянах

Данс, картын гүйлгээний мэдээллийг тогтмол шалгах.



Хариуцлагатай ашиглах

Технологи нь таны санхүүгийн шийдвэр гаргалтад туслах зорилготой гэдгийг анхаарах.

ХУВИЙН САНХҮҮГ САЙЖРУУЛАХАД АШИГЛАЖ БОЛОХ ДИЖИТАЛ ХЭРЭГСЛҮҮД

Санхүүгийн сахилга бат, төлөвлөлтийг сайжруулах, мөнгөө зөв удирдах зэргээр хувийн санхүүг сайжруулахад тусалдаг олон төрлийн дижитал хэрэгсэл байдаг. Тухайлбал,



01 ТӨЛӨВЛӨЛТ БА ЗАРДЛЫН ХЯНАЛТ

Дижитал төсөвлөлтийн хэрэгслүүд нь зардлыг автоматаар ангилж, санхүүгийн шийдвэр гаргалтыг хялбаршуулдаг. Мөн олон дансыг нэгтгэн хянах, төлбөрийн сануулга авах боломж нь төсвөө үр дүнтэй удирдахад тусалдаг.

02 ТЭТГЭВРИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТООЦООЛУУР

Энэ төрлийн хэрэгслүүд нь урт хугацааны санхүүгийн төлөвлөгөөг загварчлах боломж олгодог бөгөөд олон хувилбарыг тооцож, тэтгэмж болон эрүүл мэндийн зардлыг урьдчилан тооцдог.

03 ХАДГАЛАМЖИЙН ХЭРЭГСЛҮҮД

Орлогын хэв маягт тулгуурлан хуримтлалыг автоматжуулж, тохиромжтой хэмжээг ухаалгаар тодорхойлдог. Мөн автомат хадгаламж, "ойр дүнг тоймлох" функц болон өндөр өгөөжтэй цахим дансууд нь хуримтлал хийхийг хялбарчлан өсгөхөд тусалдаг.

04 ЗЭЭЛИЙН ХЯНАЛТ БА УДИРДЛАГА

Зээлийн удирдлагын платформууд нь зээлийн оноог хянах, сайжруулах, хадгалахад иж бүрэн дэмжлэг үзүүлдэг. Мөн хувийн мэдээллийг хамгаалах хамгаалалт, зээлийн бүтээгдэхүүн харьцуулах хэрэгслүүд нь зээлийн удирдлагыг илүү оновчтой болгодог.



ЗӨВЛӨМЖ

Хувийн санхүүгээ сайжруулахад зориулсан олон төрлийн дижитал хэрэгсэл байдаг ч тэдгээрийг сонгохдоо зөвхөн ашиглахад хялбар эсэхээр хязгаарлахгүйгээр аюулгүй байдал, найдвартай байдал, бусад санхүүгийн үйлчилгээтэй холбогдох боломж, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцэж буй эсэх зэрэг хүчин зүйлсийг анхаарах нь чухал. Мөн эдгээр хэрэгслийг ашиглах явцад хувийн мэдээлэл болон нууцлалын хамгаалалтад анхаарч, баталгаатай албан ёсны хэрэгслийг ашиглахыг зөвлөж байна.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ЯПОНЫ ИНФЛЯЦ СҮҮЛИЙН ДӨРВӨН ЖИЛИЙН ДООД ТҮВШИНД ХҮРЭВ.



Япон улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй амьжиргааны өртгийн дарамтыг бууруулах хөтөлбөрийн нөлөөгөөр инфляц сүүлийн дөрвөн жилийн доод түвшинд хүрлээ. Энэ нь Японы Төв банк (BOJ)-ны бодлогын хүүг нэмэгдүүлэх шийдвэрийг хүндрүүлэх нөхцөл бүрдүүлээд байна. Японы Дотоод хэрэг, харилцаа холбооны яамны мэдээлснээр шинэ хүнсний бүтээгдэхүүний үнийг хасаж тооцдог суурь хэрэглээний үнийн индекс (core CPI) жилийн дүнгээр 1.4 хувиар өссөн нь 2022 оны гуравдугаар сараас хойших хамгийн сул өсөлт болжээ. Энэ үзүүлэлт нь шинжээчдийн 1.7 хувийн таамаглалаас доогуур гарсан. Түүнчлэн хүнс, эрчим хүчний үнийг хасаж тооцсон суурь инфляц 1.9 хувь болсон нь мөн эдийн засагчдын төсөөллөөс доогуур байна.

Хэдийгээр инфляц богино хугацаанд саарсан ч шинжээчид үүнийг түр зуурын үзэгдэл байж болзошгүй гэж үзэж байна. Ойрх Дорнод дахь геополитикийн хурцадмал байдал, ялангуяа Ирантай холбоотой зөрчилдөөнөөс үүдэн түүхий нефтийн үнэ өсөх хандлагатай байгаа нь импортын өртгийг нэмэгдүүлж, цаашид инфляц дахин эрчимжих эрсдэлийг бий болгож байна. Иймд Ерөнхий сайд Санаэ Такаичи өмнөх байр сууриасаа ухарч, нэмэлт төсөв батлах шаардлагатай гэж мэдэгдээд байгаа юм. Тэрбээр инфляцыг эрчимжихээс өнөөг хүртэл хамгаалж буй эрчим хүчний татаасыг сэргээхээр төлөвлөж байна.

Эх сурвалж: www.reuters.com

“ГАЗРЫН ТОСНЫ ХАНШ ИРЭХ ОНД БАРРЕЛЬ НЬ \$100 ОРЧИМД ХАДГАЛАГДАХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА”



Ираны дайнаас үүдэлтэй нийлүүлэлтийн алдагдлыг нөхөхийн тулд дэлхий нийт хэрэглээгээ бууруулж байгаа тул ирэх онд түүхий газрын тосны үнэ баррель нь 100 ам.доллар орчимд хадгалагдана гэж арилжаанд оролцогчид үзэж байна. “Bloomberg Intelligence”-ээс хөрөнгийн менежерүүд, эрчим хүчний зах зээлийн мэргэжилтнүүдээс бүрдсэн 126 хүнийг судалгаанд хамруулжээ. Тус судалгаанд оролцогчдын дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд Brent төрлийн газрын тосны дундаж үнэ баррель нь 81–100 ам.долларын хооронд байна гэж таамаг дэвшүүлсэн. Сүүлийн байдлаар Ираны уран болон Ормузын хоолойн асуудлаар илэрхийлсэн байр суурийн улмаас газрын тосны үнэ гурван өдөр дараалан унасны дараа эргэн сэргээд байна. Тухайлбал Brent төрлийн газрын тос баррель нь 105 ам.доллар дөхлөө. Хэдий тийм боловч энэ долоо хоногт дөрөв гаруй хувиар унаад байгаа юм. Харин WTI төрлийн газрын тосны үнэ баасан гарагийн арилжаагаар 1.3 хувиар өсөж, баррель нь 97 ам.доллар орчимд тогтворжлоо.

Эх сурвалж: www.bloomberg.com

АЛТНЫ ХАНШ ХОЁР ДОЛОО ХОНОГ ДАРААЛЛАН БУУРАХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА.

Дэлхийн зах зээл дээр алтны ханш буурах хөдөлгөөн үргэлжилж, долоо хоногийн эцсийн байдлаар хоёр дахь удаагаа дараалан уналттай хаагдах төлөв ажиглагдаж



байна. Үүнд түүхий нефтийн үнийн өсөлтөөс үүдэлтэй инфляцын дарамт нэмэгдэж, АНУ-ын Холбооны нөөцийн сан (Fed)-гийн бодлогын хүүг өсгөх хүлээлт эрчимжсэн нь голлон нөлөөлжээ.

Олон улсын алтны зах зээлд 2026 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар нэг унцын үнэ 4,520 ам.доллар болж, өмнөх долоо хоногоос 2.46 хувиар буурлаа. Энэ нь 2026 оны 1 дүгээр сард тогтоосон 5,589 ам.долларын түүхэн дээд цэгтэй харьцуулахад 16 хувийн уналт юм. Сүүлийн дөрвөн долоо хоногт алт нийт 5.2 хувиар буурсан боловч жилийн хэмжээнд 41.7 хувийн өсөлт бүртгэсэн хэвээр байна. Гэсэн хэдий ч урт хугацааны хөрөнгө оруулагчдын идэвхжил буураагүй байна.

Дэлхийн Алтны Зөвлөлийн (WGC) мэдээгээр 2026 оны нэгдүгээр улиралд дэлхийн алтны нийт эрэлт ОТС хөрөнгө оруулалтыг оруулан жилийн өмнөхөөс 2 хувиар нэмэгдэж, 1,230.9 тоннд хүрсэн байна.

АНУ-ын инфляц 2023 оноос хойш дээд түвшинд хүрсэн ч эцэст нь Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ бууруулах магадлал эрс багасжээ. Reuters агентлагийн 2026 оны эхний улиралд хийсэн алтны судалгаанд оролцсон шинжээчид 2026 оны алтны дундаж үнийг 4,916 ам.доллар


байна гэж төсөөлсөн нь 2012 оноос хойших хамгийн өндөр гарсан таамаг гэж онцолж байна. Шинжээчдийн үзэж буйгаар төв банкнуудын алтны худалдан авалт өссөн хэвээр байгаа нь үнийг дэмжих гол хүчин зүйл болж байгаа бөгөөд ялангуяа хөгжиж буй орнууд ам.долларын хамаарлаа бууруулах зорилгоор алтны нөөцөө нэмэгдүүлж байгаа нь зах зээлд хүчтэй дэмжлэг үзүүлж байна харж байна.

Үүний зэрэгцээ Энэтхэг улс алт, мөнгөний импортын татварыг 6 хувиас 15 хувь болгон нэмэгдүүлсэн бөгөөд үнэт металлын гадаад худалдан авалтыг хязгаарлах, мөн улсын валютын нөөцөд ирэх дарамтыг бууруулах зорилготой гэж тайлбарлажээ. Дэлхийн хамгийн том алт импортлогч орнуудын нэг болох тус улсын энэхүү шийдвэр олон улсын зах зээл дээр алтны эрэлтийг сааруулах эрсдэл дагуулж болзошгүй гэж шинжээчид үзэж байна.

Эх сурвалж: www.reuters.com

SPACEX: ТҮҮХЭН ДЭХ ХАМГИЙН ТОМ IPO ХИЙХЭЭР ЗЭХЭЖ БАЙНА

АНУ-ын бизнес эрхлэгч Элон Маскийн үүсгэн байгуулсан SpaceX компани хөрөнгийн зах зээлд анх удаа хувьцаагаа санал болгох (IPO) үйл



явцыг эхлүүлж, Уолл Стритийн түүхэн дэх хамгийн том арилжаа болох төлөвтэй байна. Компанийн танилцуулсан анхан шатны баримтаас үзэхэд SpaceX ойролцоогоор 75 тэрбум ам.доллар татан төвлөрүүлэх, зах зээлийн үнэлгээг 1.7–2 их наяд ам.долларт хүргэх зорилт тавьсан нь өмнөх дээд амжилтыг шинэчлэх боломжтой юм. Reuters агентлагийн мэдээлснээр SpaceX-ийн хувьцааны арилжаа ойрын хугацаанд Nasdaq биржид "SPCX" тикертэйгээр бүртгэгдэхээр төлөвлөж байна. IPO-гийн материалд дурдсанаар SpaceX 2026 оны эхний улиралд \$4.70 тэрбумын орлого олж, \$4.30 тэрбумын алдагдал хүлээн авсан. AI сегмент нэг улиралд \$2.5 тэрбумын алдагдалтай бол нийт хуримтлагдсан алдагдал \$41.3 тэрбум болжээ. Хөрөнгийн зардлын \$7.72 тэрбум нь AI-д зарцуулагдсан байна. Үндсэн мэдэгдлийн дагуу 6 дугаар сарын 12 ны өдөр бүртгэл хийгдэх төлөвтэй байна.

